



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ  
ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**АУДИТЫН КОД: БНА-2022/20-3-ШТА-ГА**

**УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ  
НЭМЭГДҮҮЛЭХЭД ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛЖ БАЙГАА Ч ГАРСАН БОДИТ ҮР ДҮНГ НЭГТГЭН  
ТООЦОХГҮЙ БАЙГААГААС АЖИЛГҮЙДЭЛ БУУРАХГҮЙ БАЙНА.**

---

Энэх Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу  
Цахим хуудас: [www.tailan.audit.mn](http://www.tailan.audit.mn)

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга,**  
**тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**  
Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
**Аудитын менежер А.Цээням**

Утас: 70442424 цахим хуудас: [tseenyma@audit.gov.mn](mailto:tseenyma@audit.gov.mn)

**Ахлах аудитор Б.Должмаа**

Утас: 88110538 цахим хуудас: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

**Аудитор Н.Бүнчинсүрэн**

Утас: 99049866 цахим хуудас: [bunchinsurenn@audit.gov.mn](mailto:bunchinsurenn@audit.gov.mn)

Баянхонгор хот 2022 он



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/12

Номгон

Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалаар батлагдсан “Эрх шилжүүлэх” тухай тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /Б.Должмаа/-д үүрэг болгосугай.

3. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 21 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Б.Должмаа/, аудитор /Н.Бүнчинсүрэн/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер /А.Цэзэням/-д тус тус даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б. МӨНХБАТ



2022.alban bichig.tushaal

005010038

## Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь  
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор  
Б.Мөнхбат

Аудитын менежер  
А.Цээням

## Тайланг бэлтгэсэн

Ахлах аудитор  
Б.Должмаа

Аудитор  
Н.Бүнчинсүрэн

2022 оны 5 дугаар сарын  
4-ний өдөр

Уг тайланг УАГ-ын  
Цахим хуудаснаас үзнэ үү:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах  
зүйл байвал 70442424  
дугаарын утас, 70442584  
дугаарын факсаар  
харилцана уу.

### ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь  
Төрийн аудитын газар  
Аймгийн ЗДТГ-ын байр,  
Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг-64000  
Монгол Улс

## АГУУЛГА

|                                                                                                                                                                                                                                                                                                                                |    |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ...                                                                                                                                                                                                                                                                       | 5  |
| АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ                                                                                                                                                                                                                                                                                               | 5  |
| АУДИТЫН ЗОРИЛТ                                                                                                                                                                                                                                                                                                                 | 5  |
| АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ                                                                                                                                                                                                                                                                                                         | 5  |
| АУДИТЫН АРГА ЗҮЙ                                                                                                                                                                                                                                                                                                               | 5  |
| АУДИТАД АШИГАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ                                                                                                                                                                                                                                                                                              | 6  |
| АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА, АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН                                                                                                                                                                                                                                                                        | 6  |
| АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ,<br>ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ЖУРАМ                                                                                                                                                                                                                                                     | 6  |
| ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ                                                                                                                                                                                                                                                                                                               | 6  |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР                                                                                                                                                                                                                                                                                                        | 7  |
| ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ                                                                                                                                                                                                                                                                                                                | 8  |
| БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ<br>НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГЫГ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО,<br>ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАН ОРОН НУТГААС САНХҮҮЖҮҮЛСЭН БОЛОВЧ ҮР<br>ДҮНГ НЭГТГЭН ТООЦОЖ АЖИЛЛААГҮЙ<br>БАЙНА                                                                                                                | 10 |
| 1.1. Үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой<br>уялдуулан боловсруулсан хөгжлийн бодлого баримт бичгүүдэд хөдөлмөр<br>эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх<br>арга хэмжээнүүдийг тусгасан байна                                                                      | 9  |
| 1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд шаардлагатай санхүүжилтийг<br>тооцохдоо харьяа байгууллагын саналыг харгалздаггүй үндэслэл муутай<br>төлөвлөж байна                                                                                                                                                                       | 11 |
| 1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын ажлын<br>уялдаа, хамтран ажиллах байдал хангалтгүй байна                                                                                                                                                                                                       | 13 |
| БҮЛЭГ 2. ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙРЫГ ТӨСӨЛ<br>ХЭРЭГЖҮҮЛЭГЧЭЭС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЛЭЭР ТАЙЛАН МЭДЭЭГ<br>НЭГТГЭН ТАЙЛАГНАЖ БАЙГАА НЬ БОДИТ БАЙДЛААС ЗӨРҮҮТЭЙ,<br>АЖИЛТНЫ ЦАЛИНГ НИЙГМИЙН ДААТГАЛД МЭДЭЭЛЭЭГҮЙ НЬ ХӨДӨЛМӨР<br>ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ БИЙ БОЛГОХ АРГА<br>ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ БУУРУУЛАХ ГОЛ НӨХЦӨЛ БОЛЖ БАЙНА | 19 |
| 2.1. Баянхонгор аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс ажил орлогогүй иргэдээс<br>судалгаа авч, дүн шинжилгээ хийх, тэднийг мэдээллээр хангах ажил<br>хангалтгүй байна                                                                                                                                                                   | 19 |
| 2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлэг бууруулах, ажлын байр<br>нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр<br>дүнд ажлын байр нэмэгдэж байгаа ч ажилгүйдэл өссөн байна                                                                                                                     | 23 |
| 2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг ХЭДС-д бүрэн<br>төвлөрүүлсэн байна                                                                                                                                                                                                                                             | 26 |
| 2.4. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг жилд дунджаар 737<br>суралцагч төгсөж, тэдний 55.9 хувь нь ажлын байртай болжээ                                                                                                                                                                                             | 39 |
| 2.5. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч<br>хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгээ өгсөн байна                                                                                                                                                                                                         | 39 |
| АУДИТЫН ДҮГНЭЛТ                                                                                                                                                                                                                                                                                                                | 47 |
| АУДИТЫН ЗӨВЛӨМЖ                                                                                                                                                                                                                                                                                                                | 48 |
| ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ                                                                                                                                                                                                                                                                                        | 49 |

## АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

### Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн аудитыг гүйцэтгэв.

### Аудитын зорилт

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв.

Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх
2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх

### Аудитын хамарсан хүрээ

Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгасан төсөл, хөтөлбөр, зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2016-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа. Мөн “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК, СХС-аас олгосон зээл, ЖДҮХС-аас арилжааны банкаар дамжуулсан олгосон зээлийг тус аудитад хамруулав.

### Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100,300,3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглав. Дээрх арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, иргэдээс санал асуулга авах зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

## Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7 дахь заалт
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 3-20 дугаар зүйл; /2015 он/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 3-6, 8-21, 24 дүгээр зүйл
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих тухай хуулийн 4-26 дугаар зүйл; /2011 он/
- Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хууль;
- Монгол Улсын 2017-2021 оны төсвийн тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; /2006 он/
- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- УИХ-ын 2001 оны 57, 2016 оны 4, 19, 45, 320, 2019 оны 55, 2020 оны 23, 24, 52 дугаар тогтоолууд;
- Засгийн газрын 2011 оны 375, 2016 оны 121, 276, 2017 оны 89, 2018 оны 140, 2019 оны 290, 2020 оны 206, 2021 оны 42, 119 дүгээр тогтоолууд;
- НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 70 дугаар чуулганаар баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго-2030”;
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

## Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээнэм үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Н.Бүнчинсүрэн нар 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2020 оны 5 дугаар сарын 05-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

## Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам

Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичиж, аудитын тайланд аудитын менежер, тэргүүлэх аудитор нараар үе шатны хяналт хийлгэж, тайланг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн ХХҮГ-т хүргүүлэв.

## Хүндрэл бэрхшээл

### Аудитыг гүйцэтгэхэд дараах хүндрэл бэрхшээл тулгарсан:

- Олон жилийг хамарсан тул өмнөх онуудын баримтуудыг архиваас авахад цаг хугацаа их шаардсан;
- Шалгагдагч байгууллага болон хамрагдагч байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд солигдсон;
- Холбогдох мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалж, зарим баримт материал архиваас олдоогүй
- Аудитад шаардлагатай мэдээллийг цахимаар сан болгон бүрдүүлээгүй;

- Аудитын цаг хугацаа санхүүгийн тайлангийн аудиттай давхацсан тул аудитын хугацаа бага байсан.
- Баянхонгор аймгийн “Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих” аймгийн дэд хөтөлбөрт “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлого, амьжиргааг сайжруулж, ядуурлаас гаргах” зорилтын хүрээнд 16 дэд зорилт дэвшүүлсэн тусгасан ба тус дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн НБХ, Гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн газраас удаа шаардуулж ирүүлсэн;

### Товчилсон үгийн тайлбар

АДБОУС  
ГБХЗХГ  
ДХШУДАХ  
ЖДҮХС  
ЖДҮ  
ЗДТГ  
ИТХ  
СТСХ  
ТЕГ  
ТЗУХ  
ТББ  
МСҮТ  
НДЕГ  
ҮАГ  
ХНХЯ  
ХХААХҮЯ  
ХХААХҮС  
ХХҮЕГ  
ХЭҮЗ  
ХЭДС  
ХХААГ  
ХХҮГ  
ХХК  
ХХОАТ  
ОНӨААТҮГ  
УИХ  
УБЕГ

Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар  
Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс  
Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан  
Жижиг дунд үйлдвэрлэл  
Засаг даргын Тамгын газар  
Иргэдийн төлөөлөгчдийн хурал  
Санхүү төрийн сангийн хэлтэс  
Татварын Ерөнхий газар  
Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс  
Төрийн бус байгууллага  
Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв  
Нийгмийн даатгалын Ерөнхий газар  
Үндэсний аудитын газар  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам  
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам  
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газар  
Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл  
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан  
Хүнс, хөдөө аж ахуйн газар  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар  
Хязгаарлагдмал хариуцлагатай компани  
Хувь хүний орлогын албан татвар  
Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар  
Улсын Их Хурал  
Улсын бүртгэлийн Ерөнхий газар

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

ХХҮЕГ-ын даргын 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн Б/21 дүгээр тушаалаар Баянхонгор аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын орон тооны дээд хязгаарыг баталж, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийг 7 хүний орон тоотой баталснаас хэлтсийн дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 5 ажиллаж байна.

ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсгийг аймгийн ХХҮГ-ын дарга Ц.Амарсанаа, хоёрдугаар гарын үсгийг ахлах мэргэжилтэн Ц.Алтанцэцэг нар зуржээ.

Аймгийн ХЭДС-аас 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 6,689.0 сая төгрөгийг зарцуулснаас 35.0 хувь буюу 2,344.3 сая төгрөгийг ажлын байрыг дэмжих хөтөлбөрт, 30.5 хувь буюу 2,042.9 сая төгрөгийг малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан нь дийлэнх хувийг эзэлсэн байна.

| Баримт бичгийн нэр                                                                                                | Хугацаа   | Хөрөнгийн дүн  | Эзлэх хувь  |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|----------------|-------------|
| Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний зардал                                                                   | 2016-2021 | 147.5          | 2.2         |
| Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр                                                   | 2016-2021 | 360.0          | 5.4         |
| Ажлын байрыг дэмжих хөтөлбөр                                                                                      | 2016-2021 | 2,344.3        | 35.0        |
| Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр                                                    | 2016-2021 | 390.5          | 5.8         |
| Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр                                                                       | 2016-2021 | 2,042.9        | 30.5        |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр                                                         | 2016-2021 | 463.8          | 6.9         |
| Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр                                                           | 2016-2021 | 203.9          | 3           |
| Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой зорилтот төслийн санхүүжилт | 2016-2021 | 200.0          | 3           |
| Хүүхэд хамгаалагч төсөл                                                                                           | 2016-2021 | 8.4            | 0.1         |
| <b>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний зардлын дүн</b>                                            |           | <b>6,161.4</b> | <b>92.1</b> |
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал                                                                 | 2016-2021 | 424.1          | 6.3         |
| Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр                                                                 | 2016-2021 | 103.4          | 1.6         |
| <b>Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн зарлагын дүн</b>                                                            |           | <b>6,689.0</b> | <b>100</b>  |

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан, зөвлөлийн өөрийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс төрийн байгууллагуудын үйл ажиллагааны харилцан уялдаа хангалтгүй, аймгийн хэмжээнд тухайн жилд бий болж буй ажлын байрыг нэгтгэн, тайлагнадаггүй байна.

Орон нутгийн хөрөнгөөс ЖДҮ хөгжүүлэх зорилгоор хөрөнгийг баталж, хүүгүй зээлийг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аар дамжуулан олгосноос гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан инкубатор бизнесийн Ажилсаг төв, ахуйн үйлчилгээний төв зэрэг барилгуудад зээл авсан иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулснаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмрийг оруулсан байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо хангалтгүйгээс ХЭДС, орон нутгийн нөөц хөрөнгө, сум хөгжүүлэх сан, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК, арилжааны банкаар дамжуулан ЖДҮ-ийг хөгжүүлэх зорилго бүхий хөнгөлөлттэй зээлийн дүнд аймгийн хэмжээнд жилд хэчнээн хүн төсөл, хөтөлбөрт хамрагдаж, ямар хэмжээний хөрөнгийг ажлын байр нэмэгдүүлэхэд зориулж, хэдэн ажлын байр бий болсныг нэгтгэн гаргаагүй байна.

Аудитаар явцад авч нэгтгэсэн судалгаагаар Баянхонгор аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2015-2021 онд зарцуулсан хөрөнгийн үр дүнг нэгтгэн гаргасан судалгаагаар аймгийн хэмжээнд 35,039 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан нийт 11,948.5 сая төгрөгийг зарцуулсны үр дүнд 7,214 байнгын, 7,903 түр ажлын байр бий болсон байна.

Аймгийн хэмжээнд ямар мэргэжил эрэлт хэрэгцээтэй байгаа, ажилгүй иргэд ямар шалтгааны улмаас хөдөлмөрийн хэлтэст сайн дураараа бүртгүүлэхгүй байгаа талаар нэгдсэн судалгаа байхгүй байна.

ХЭДС болон бусад эх үүсвэрээс хөнгөлөлттэй зээлийг олгохдоо төслийг хүлээн авч хэлэлцэхдээ ирсэн санхүүжилтийн хүрээнд олон иргэдийг хамруулах зорилгоор ирүүлсэн төслийн мөнгөн дүнг бууруулан олгож байгаа нь тухайн төслийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болох, бүрэн хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн дэмжлэгийг хугацаанд нь төлөхгүй, хугацаа хэтэрсэн авлагыг нэмэгдүүлсээр байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд шаардлагатай санхүүжилтийг төлөвлөхдөө харьяа байгууллагын саналыг харгалздаггүй, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг дутуу, санд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг төлөвлөөгүй байна.

ХЭДС болон бусад эх үүсвэрээс тусламж, санхүүгийн дэмжлэг, зээл олгосноор хэдэн ажлын байр бий болж байгаад хяналт хэрэгжүүлэхдээ нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа эсэхэд хяналт тавиагүй, мэдээ, тайланд бий болсон ажлын байрны тоог иргэдээс өгсөн тоогоор мэдээлснээс ажлын байрны тоо бодит байдлаас өндрөөр мэдээлэгдэж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн LMIS программд ХНХЯ-ны харьяа байгууллагуудын мэдээлэл бүрэн холбогдоогүйгээс ашиглалт хангалтгүй, аудитын явцад системийн ашиглалттай танилцахад гацалт их, шаардлагатай мэдээллийг авахад хугацаа их шаарддаг зэргээс харахад системд хөгжүүлэлтийг хийж, орон нутагт системийн хурдыг нэмэх шаардлагатай болсон байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг баталсан хэдий ч орон нутгаас төсөв батлаагүйгээс ажил хийгдээгүй байна.

“Ковид-19” цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгээ өгсөн байна.

Монгол Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар танхимын гэрээгээр гүйцэтгэсэн “Баянхонгор аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны ажлын тайланг хэлэлцээгүй, үр дүнг тооцоогүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бизнес инкубаторын зориулалтаар баригдсан “Ажилсаг” төвд түрээслэгч ямар хугацаанд ажиллах талаар бодлого, чиглэлийг тодорхойлоогүй, ахуйн үйлчилгээний төвд 6 аж ахуйн нэгж 8 өрөөг түрээслэн ахуйн үйлчилгээнээс бусад чиглэлийн үйл ажиллагаа явуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийг тусгасан Баянхонгор аймгийн ИТХ-аар баталсан дэд хөтөлбөрүүдийг боловсруулах үе шатанд хийж гүйцэтгэсэн тооцоолол, судалгааны ажлын баримт, материал зэрэг нотлох баримтыг аудитын явцад ирүүлээгүй тул эдгээр аймгийн дэд хөтөлбөрүүдэд бүх талын оролцоо хангагдсан эсэхийг дүгнэх боломжгүй байна.

## АУДИТЫН ДҮН

### **БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГЫГ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАН ОРОН НУТГААС САНХҮҮЖҮҮЛСЭН БОЛОВЧ ҮР ДҮНГ НЭГТГЭН ТООЦОЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

**1.1. Үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулан боловсруулсан хөгжлийн бодлого баримт бичгүүдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байна.**

1.1.1. Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2015 оны 6 дугаар тогтоолоор аймгийг хөгжүүлэх хэтийн зорилт боловсруулах ажлын хэсгийг 25 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар аймгийн ИТХ-ын дарга ажиллаж, аймгийн ИТХ-ын 2015 оны 15 дугаар хуралдаанаар “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ыг 2 үе шаттай хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилтод 5 үндсэн зорилтын хүрээнд 81 дэд зорилтыг хэрэгжүүлэх, үүнээс эхний үе шатыг 2016-2020 он, удаах үе шатыг 2021-2025 онд хэрэгжүүлэхээр тусгаж, 2016 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн аймгийн ИТХ-ын хуралдааны 15/2 дугаар тогтоолоор баталжээ.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2016 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 2/3 дугаар тогтоолоор “Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийг баталж, 5 үндсэн зорилтын хүрээнд 153 дэд зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Мөн Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 13 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр”-ийг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр баталжээ.

Холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулсан дээрх бодлогын баримт бичгүүд болон Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байна.

1.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4<sup>1</sup>, 30.1.14 дэх заалтыг ХХҮЕГ хэрэгжүүлээгүй, харьяа байгууллагуудад хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, төлөв байдалд дүн шинжилгээ хийх чиглэл өгч ажиллаагүй, хэтийн тооцооллын загварыг боловсруулаагүй байна.

#### **Аудитын илрүүлэлт**

- Баянхонгор аймгийн ХХҮГ нь Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг аймгийн хэмжээнд тодорхойлох, тооцох талаар арга хэмжээ авч ажиллаагүй, зөвхөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зориулсан эрэлтийн судалгааг авсан зөрчил илэрлээ.

<sup>1</sup> Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, богино, дунд хугацааны болон хэтийн зорилтыг боловсруулах;

Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Герман улсын “GFA” компанийн хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын Баруун бүсийн Мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн санхүүжилтээр “Баянхонгор аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн тоон болон чанарын судалгаа”-г 2015 онд аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтнээр ахлуулсан 15 хүний бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэсэн байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын захиалгаар НБХ, Монгол Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар танхимтай 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр “Аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа”-ны 2021/229 тоот гэрээ байгуулан, 10.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Баянхонгор аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны ажлыг гүйцэтгэсэн байна.

Гэрээний хавсралтаар “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-г тодорхойлж, судалгааны зорилгыг хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны /2022 он/ ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тодорхойлж, аймгийн 19 сум болон аймгийн төвийн 214 аж ахуйн нэгж, байгууллага, 4 мянга гаруй ажиллагсдыг оролцуулсан гэж тэмдэглэжээ.

#### **Аудитын илрүүлэлт**

- “Аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны гэрээнд судалгааны үр дүнг хэлэлцэх талаар тусгаагүй, тус судалгааны тайлан, үр дүнг хэлэлцээгүй, Монгол Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар аудитын явцад төрийн аудитын байгууллагад мэдээлэл өгөөгүй;
- Баянхонгор аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд 2015, 2021 онд судалгааг хийхдээ мэргэжлийн байгууллага болох ХХҮГ-ын албан тушаалтнуудыг оролцуулаагүй байна.

Иймд Монгол Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар танхимын гэрээгээр гүйцэтгэсэн ажлын тайланг хүлээн авч баталж, үр дүнг тооцож аймгийн бодлого, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын НБХ-т хүргүүлэв.

Баянхонгор аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, өнөөгийн чиг хандлагыг тодорхойлох ажлыг мэргэжлийн байгууллагууд, бодлого тодорхойлох чиг үүрэг бүхий алба, хэлтсийн албан хаагчдыг оролцуулж байх шаардлагатай байна.

1.1.3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2<sup>2</sup>-т заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэгчид, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийн хуулийн этгээд оролцохоор заажээ.

Аймгийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөрийн таатай орчин, хөдөлмөрийн зах зээлд тэгш боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох үндсэн зорилго бүхий “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг баталсан байна.

Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах зүйл, заалт бүхий 6 аймгийн дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар баталсан байна. Үүнд:

1. “Илгээлтийн эзэн” аймгийн дэд хөтөлбөр
2. “Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих” аймгийн дэд хөтөлбөр
3. “Залуучуудыг дэмжих” дэд хөтөлбөр” аймгийн дэд хөтөлбөр
4. “Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого”

<sup>2</sup> Энэ хуулийн 8.1-д зааснаас бусад төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухааны төв байгууллага, төрийн өмчит хувьцаат компани, сан, Хөгжлийн банк, төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэгчид, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийн хуулийн этгээд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцоно.

5. “Ахмадаа ачлая” аймгийн дэд хөтөлбөр
6. “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийг тусгасан Баянхонгор аймгийн ИТХ-аар баталсан дэд хөтөлбөрүүдийг боловсруулах үе шатанд хийж гүйцэтгэсэн тооцоолол, судалгааны ажлын баримт, материал зэрэг нотлох баримтыг аудитын явцад ирүүлээгүй тул эдгээр аймгийн дэд хөтөлбөрүүдэд бүх талын оролцоо хангагдсан эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Иймд аймгийн ИТХ-аар баталсан аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулах үе шатны ажлын баримт болон, хэрэгжилтийн тайланг гаргаж ирүүлэх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-т хүргүүлэв.

## 1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд шаардлагатай санхүүжилтийг тооцохдоо харьяа байгууллагын саналыг харгалздаггүй үндэслэл муутай төлөвлөж байна.

1.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төслийг боловсруулахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо, сангийн өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэн хэрэгцээ шаардлагаа тодорхойлж ХХҮЕГ-т хүргүүлдэг байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төсөөллийг 6 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2016 онд 2,081.1 сая, 2017 онд 2,647.5 сая, 2018 онд 3,018.6 мянга, 2019 онд 1,194.0 сая, 2020 оноос эхлэн 8 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,511.1 сая, 2021 онд 1,729.0 сая төгрөг нийт 12,181.3 сая төгрөгийг төсвийг хүргүүлж, оны эхэнд 7,623.0 сая төгрөг батлагдаж ирсэн бөгөөд оны дундуур төсөвт тодотгол хийж оны эцэст 6,377.3 сая төгрөг болон тодотгосон байна.

Хүснэгт 1. Төсвийн төсөл, анхны болон тодотгосон төсөв (сая төгрөгөөр)

| Он   | Төсвийн төсөл |          | Анх батлагдсан төсөв |         | Тодотгосон төсөв |         | Зөрүү    |         |
|------|---------------|----------|----------------------|---------|------------------|---------|----------|---------|
|      | хүн           | хөрөнгө  | хүн                  | хөрөнгө | хүн              | хөрөнгө | хүн      | хөрөнгө |
| 2016 | 4,892.0       | 2,081.1  | 4,124.0              | 1,169.1 | 4,124.0          | 1,169.1 | 768.0    | 912.0   |
| 2017 | 5,772.0       | 2,647.5  | 3,780.0              | 1,253.9 | 4,311.0          | 991.3   | 1,992.0  | 1,393.6 |
| 2018 | 6,338.0       | 3,018.6  | 3,590.0              | 1,592.5 | 3,614.0          | 1,094.4 | 2,748.0  | 1,426.1 |
| 2019 | 4,386.0       | 1,194.0  | 1,230.0              | 1,138.0 | 1,398.0          | 1,244.6 | 3,156.0  | 56.0    |
| 2020 | 6,941.0       | 1,511.1  | 1,403.0              | 1,828.8 | 3,469.0          | 1,150.9 | 5,538.0  | (317.7) |
| 2021 | 7,440.0       | 1,729.0  | 4,662.0              | 640.8   | 3,725.0          | 727.0   | 2,778.0  | 1,088.2 |
| Дүн  | 35,769.0      | 12,181.3 | 18,789.0             | 7,623.0 | 20,641.0         | 6,377.3 | 16,980.0 | 4,558.2 |

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2016-2021 оны төсвийн төсөл, төсвийн хуваарь

Дээрх судалгаанаас харахад ХНХЯ-д хүргүүлсэн төсвийн төслийг 2016-2021 онд дунджаар 37.4 хувь буюу 4,558.2 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

1.2.2. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд 2016-2021 онд 6,319.2 сая төгрөгийн эх үүсвэрийг санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,462.6 сая, орон нутгийн төсвөөс 390.0 сая, гадаад улс, олон улсын байгууллагын зээл тусламжаас 107.1 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний орлогоос 173.5 сая, зээлийн эргэн төлөлтөөс 1,441.3 сая, өмнөх оны үлдэгдлээс 27.4 сая нийт 7,601.9 сая төгрөгийн санхүүжилт авч 6 хөтөлбөр 2 арга хэмжээг арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 2. ХЭДС-ийн эх үүсвэр (сая төгрөгөөр)

| Он   | Үзүүлэлт   | ХЭДС-ийн санхүүжилт | Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө | Гадаад улс, олон улсын байгууллагын зээл тусламж | ХБИ ажиллуулаагүй орлого | Зээлийн эргэн төлөлт | Өмнөх оны үлдэгдэл | Нийт    |
|------|------------|---------------------|------------------------------------------|--------------------------------------------------|--------------------------|----------------------|--------------------|---------|
| 2016 | Төлөвлөгөө | 1,161.1             |                                          |                                                  | 8.0                      |                      |                    | 1,169.1 |
|      | Гүйцэтгэл  | 748.0               |                                          |                                                  | 1.0                      | 42.2                 | 7.6                | 798.8   |
| 2017 | Төлөвлөгөө | 991.3               |                                          |                                                  |                          |                      |                    | 991.3   |
|      | Гүйцэтгэл  | 957.5               | 90.0                                     |                                                  | 1.1                      | 141.4                |                    | 1,190.0 |
| 2018 | Төлөвлөгөө | 1,094.4             |                                          |                                                  |                          |                      |                    | 1,094.4 |

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн

|      |            |         |       |       |       |         |
|------|------------|---------|-------|-------|-------|---------|
|      | Гүйцэтгэл  | 1,053.5 | 100.0 | 2.9   | 242.8 | 1,399.2 |
| 2019 | Төлөвлөгөө | 1,241.1 |       | 3.4   |       | 1,244.5 |
|      | Гүйцэтгэл  | 1,240.0 | 100.0 | 4.8   | 363.8 | 1,728.4 |
| 2020 | Төлөвлөгөө | 1,147.4 |       | 3.5   |       | 1,150.9 |
|      | Гүйцэтгэл  | 779.7   | 100.0 | 67.4  | 156.3 | 1,474.6 |
| 2021 | Төлөвлөгөө | 683.9   |       | 39.7  | 3.5   | 727.1   |
|      | Гүйцэтгэл  | 683.9   |       | 39.7  | 7.4   | 279.9   |
|      | Төлөвлөгөө | 6,319.2 | -     | 39.7  | 18.4  | -       |
| Дүн  | Гүйцэтгэл  | 5,462.6 | 390.0 | 107.1 | 173.5 | 1,441.3 |
|      |            |         |       |       |       | 27.4    |
|      |            |         |       |       |       | 7,601.9 |

Эх сурвалж: ХЭДС-ийн санхүүгийн тайлангууд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд сангийн эх үүсвэрийн бүрэлдэхүүнд орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө байхаар заасан ба 2016, 2021 онд хөрөнгө хуваарилаагүй, 2017 онд 90.0 сая, 2018 онд 100.0 сая, 2019 онд 100.0 сая, 2020 онд 100.0 нийт 390.0 сая төгрөг хуваарилсан байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-т<sup>3</sup>, Засгийн газрын 2009 оны 29 дүгээр тогтоолын хавсралтад заасан<sup>4</sup>, Засгийн газрын 2019 оны “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтад заасан<sup>5</sup>-аар тооцохоор тус тус тогтоосон байна.

Аймгийн хэмжээнд 2016-2021 онд 25-аас дээш тооны ажиллагсадтай 376 аж ахуй нэгжид 793 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллахаар байхад 697 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилласан тул ажиллуулаагүй 96 хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй төлбөрт 414.6 сая төгрөгийг төлөхөөр байхад гүйцэтгэлээр тус онд 173.2 сая төгрөгийг санд төвлөрүүлж, 241.4 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 3. ХБИ ажиллуулаагүй орлогын судалгаа (сая төгрөгөөр)

| Үзүүлэлт                      | 2016 | 2017 | 2018 | 2019  | 2020  | 2021 | Дүн   |
|-------------------------------|------|------|------|-------|-------|------|-------|
| ААНБ-ын тоо (25 түүнээс дээш) | 29   | 51   | 54   | 76    | 81    | 85   | 376   |
| Ажиллавал зохих ХБИ           | 81   | 99   | 104  | 148   | 215   | 146  | 793   |
| Ажиллаж буй ХБИ-ний тоо       | 72   | 76   | 88   | 152   | 179   | 130  | 697   |
| ХБИ зөрүү                     | 9    | 23   | 16   | -4    | 36    | 16   | 96    |
| Төлбөл зохих зохих мөнгөн дүн | 18.4 | 34.8 | 24.2 | 112.6 | 155.5 | 69.1 | 414.6 |
| Төлбөр төлсөн мөнгөн дүн      | 1.0  | 1.1  | 2.6  | 4.8   | 156.3 | 7.4  | 173.2 |
| Төлбөрийн зөрүү               | 17.4 | 33.7 | 21.6 | 107.8 | -0.8  | 61.7 | 241.4 |

Эх сурвалж ХХҮГ-ын статистик мэдээ тайлан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөр төлсөн байгууллагыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. ХБИ ажиллуулаагүйн төлбөр төлсөн ААН-ийн судалгаа (сая төгрөгөөр)

| Төлбөр төлсөн ААНБ-ын нэр    | 2016 он   |                      | 2017 он   |                      | 2018 он   |                      | 2019 он   |                      | 2020 он   |                      | 2021 он   |                      | Нийт Дүн  |                      |
|------------------------------|-----------|----------------------|-----------|----------------------|-----------|----------------------|-----------|----------------------|-----------|----------------------|-----------|----------------------|-----------|----------------------|
|                              | Хүний тоо | Төлбөр төлсөн хэмжээ | Хүний тоо | Төлбөр төлсөн хэмжээ | Хүний тоо | Төлбөр төлсөн хэмжээ | Хүний тоо | Төлбөр төлсөн хэмжээ | Хүний тоо | Төлбөр төлсөн хэмжээ | Хүний тоо | Төлбөр төлсөн хэмжээ | Хүний тоо | Төлбөр төлсөн хэмжээ |
| Баянбулаг сумын сургууль     | 1         | 0.7                  | 1         | 0.9                  | 1         | 0.9                  | 1         | 1.1                  | 1         | 3.4                  | 1         | 3.4                  | 6         | 10.2                 |
| Баянхонгор сум 11-р цэцэрлэг |           |                      |           |                      | 1         | 0.9                  |           |                      |           |                      |           |                      | 1         | 0.9                  |
| Богд сумын сургууль          |           |                      |           |                      | 1         | 0.8                  |           |                      | 1         | 0.6                  | 1         | 4.0                  | 3         | 5.5                  |
| ХААН банк                    |           |                      |           |                      |           |                      | 2         | 1.7                  |           |                      |           |                      | 2         | 1.7                  |
| Наранмандал энтерпрайзес ХХК | 1         | 0.3                  |           |                      |           |                      | 4         | 2.0                  | 11        | 152.3                |           |                      | 16        | 154.7                |
| Хонгорын хүдэр ХХК           |           |                      | 1         | 0.2                  |           |                      |           |                      |           |                      |           |                      | 1         | 0.2                  |
| <b>Нийт дүн</b>              | <b>2</b>  | <b>1.0</b>           | <b>2</b>  | <b>1.1</b>           | <b>3</b>  | <b>2.6</b>           | <b>7</b>  | <b>4.8</b>           | <b>13</b> | <b>156.3</b>         | <b>2</b>  | <b>7.4</b>           | <b>29</b> | <b>173.2</b>         |

Эх сурвалж: ХЭДС-ийн санхүүгийн тайлан

<sup>3</sup> 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна

<sup>4</sup> Аж ахуй нэгж байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар

<sup>5</sup> Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулах орон тоог аж ахуй нэгж байгууллагын нийт ажиллагчдын 25 хүн тутамд 1 гэж тооцож тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн 60 хувиар

Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг төлөвлөх хэрэгжүүлэхэд дараах хүндрэл үүсдэг гэсэн тайлбарыг шалгагдагч байгууллагаас ирүүлсэн байна. Үүнд:

- Ажил олгогчид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2<sup>6</sup> дах заалтыг хэрэгжүүлдэггүй;
- Орон тоо 25-аас дээш ажилтантай аж ахуй нэгж байгууллагуудын 90-ээс дээш хувь нь төрийн байгууллагууд байдаг учир төсөвт холбоотой зардал батлагддаггүй гэсэн шалтгаанаар төлбөр төлдөггүй;
- Аж ахуй нэгж, байгууллага дундаж цалинг үнэн зөв мэдээлдэггүй;
- Хөдөлмөрийн хэлтсийн тус хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн улсын байцаагчийн эрх байхгүй тул гарсан зөрчилд төлбөр тогтоох эрх байхгүй гэх мэт шалтгаануудтай байна.

Иймээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дах заалтыг хэрэгжүүлээгүй ажил олгогчийн мэдээллийг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт улирал бүр хүргүүлж, зөрчлийг арилгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэн буюу одой хүн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг тухайн жилд төлөвлөж, бүрэн төвлөрүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ХХҮГ-т хүргүүлэв.

1.2.3. Баталсан санхүүжилтийг цаг тухайд нь хуваарилаагүйгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт тасрах, удаашрах, өглөг үүсэх шалтгаан болсон байна.

ХЭҮЗ-ийн тогтоолыг үндэслэн ХХҮЕГ-ын даргын тушаалаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг тухайн оны 2-3 дугаар сард баталж байна.

Төсөл хөтөлбөрийн санхүүжилт нь хөтөлбөр тус бүрээр орж ирдэггүй, нэгдсэн дүнгээр жилд 2-3 удаа хуваагдаж орж ирсэн байна.

#### **Аудитын илрүүлэлт**

- Залуучуудыг хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр 2016 онд 99.2 сая төгрөгийг төлөвлөж санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой хэрэгжээгүй, 2020 онд цар тахлын онцгой нөхцөл байдлын улмаас санхүүжилт тасарч 41.1 сая төгрөгийг өглөг үүсэж 2021 онд барагдуулсан байна.

Төсөл хөтөлбөрийн эхний ээлжийн санхүүжилт голдуу 3, 6, 9 дүгээр сард, заримд тохиолдолд 12 дугаар сард санхүүжилт орж ирдэг, энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болох бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг тул цаашид шаардагдах санхүүгийн нөөцийг зөв зохион байгуулах шаардлагатай байна.

**1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын ажлын уялдаа, хамтран ажиллах байдал хангалтгүй байна.**

1.3.1. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Баянхонгор аймгийн Засаг даргатай, аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг тусган хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын сайдтай байгуулсан гэрээний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зорилт арга хэмжээг 2016-2021 онд дунджаар 91.3 хувьтай тайлагнасан байна.

<sup>6</sup> Ажил олгогч нь ажиллах хүч болон ажлын байрны холбогдолтой мэдээллийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид гарган өгөх, эсхүл түүний бүртгэл, мэдээллийн сүлжээнд бүртгүүлж, мэдээллээ байршуулах, мэдээлэлд оруулж байгаа өөрчлөлтийг тухай бүрд нь хийж байх үүрэгтэй бөгөөд ажил олгогч нь нийт ажлын байрныхаа талаарх мэдээллийг оны эхэнд нэг удаа, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг улирал тутам, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг тухай бүр нь энэ хуулийн 20.7-д заасан маягын дагуу харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, хөдөлмөрийн биржид гаргаж өгнө.

“Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.1<sup>7</sup> дэх заалтын дагуу орон нутгийн төсвөөс ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор тодорхой эх үүсвэрийг хуваарилан шийдэж, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь аймгийн хэмжээнд ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд чиглэл бүрээр хэрэгжиж, түүний үр дүн гарч байгаа хэдий ч тухайн жилд аймгийн хэмжээнд хэдэн ажлын байр бий болсныг нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах ажил хийдэггүй байна.

#### **Аудитын илрүүлэлт**

- Баянхонгор аймгийн ХХҮГ жилийн эцсийн тайлан, мэдээг НБХ-т, Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК нь ХОХБТ-т ирүүлж, нэгтгэн дүн шинжилгээ хийдэггүй байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.7<sup>8</sup>-т заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс төрийн байгууллагуудын үйл ажиллагааны харилцан уялдаа хангалтгүй байна.

1.3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2<sup>9</sup>-т заасны дагуу ХХҮЕГ-аас бүс нутгийн онцлогт тохирсон салбар дундын зохицуулалт хийгээгүй, хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ХХҮГ нь ажлын байр нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байгаа орон нутгийн захиргааны байгууллага, ХХААГ, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК, ГБХЗХГ, Политехникийн коллеж зэрэг газруудтай харилцан уялдаагүй, нэгдсэн мэдээллийн сан үүсгээгүй, зөвхөн ХХҮЕГ-аас баталсан төсвийн хүрээнд сургалтын үйл ажиллагаагаар холбогдож байна.

Харин Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2<sup>10</sup>-т заасны дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээнүүдийг тодорхойлон, аймгийн ИТХ-аар баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлж ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсаар иржээ.

Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийн дүнд дараах ажлууд хийгдэж, ажлын байр бий болсон байна.

“Баянхонгор ”Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги, бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бизнесийн орчныг дэмжих замаар зах зээлийг өргөжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах” эрхэм зорилгын дор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг 2016 онд байгуулсан байна.

Орон нутгийн төсвөөс ЖДҮ-ийг хөгжүүлэх зорилгоор 2012 оноос жил бүр төсөвт хөрөнгө тусган, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсээр дамжуулан

<sup>7</sup> Төсвийн тухай хуулийн 58.1.58, 58.2.5 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.2 дахь заалтын дагуу орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар зарцуулагдах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт жил бүр тусган батлуулах;

<sup>8</sup> Зөвлөл до дурдсан үүрэгтэй байна: Хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар төрийн захиргааны үйлчилгээний байгууллага, ялангуяа мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг дунд үйлдвэр, хөдөө аж ахуй, гэр бүл, залуучуудын хөгжлийн болон бусад холбогдох асуудал эрхэлсэн байгууллага, бусад хороо, зөвлөлүүдтэй үйл ажиллагаа уялдуулах

<sup>9</sup> Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: . хууль тогтоомж, дүрэм, журам, төсөл, хөтөлбөрийн болон бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ, салбарын хүрээний болон салбар дундын зохицуулалт хийх;

<sup>10</sup> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ: орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

хөнгөлөлттэй зээлийг олгожээ. Тус хэлтсээр дамжуулан 2012-2016 онд 663.0 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийг байгуулснаас хойш буюу 2017 оноос хойш одоог хүртэл тус компаниар дамжуулан зээл олгож байна.

Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор олгож буй хөнгөлөлттэй зээлийг хүүгүй олгож, зээлийн дүнгээс 5 хувиар тооцон тус корпорацийн үйл ажиллагааны зардалд эрсдэлийн сан үүсгэн авч зарцуулдаг бөгөөд 2012 оноос хойш 3,322.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноос 2,305.0 сая төгрөг нь орон нутгаас хуваарилсан санхүүжилтээс, 1,017.5 сая төгрөг нь өмнөх олгосон зээлийн эргэн төлөлтийн орлогоос олгожээ.

Хүснэгт 5. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээл (сая төгрөгөөр)

| № | Он        | Анх олгосон зээл                   |                                 | Зээлдэгчийн тоо | 2022.01.01-нээрх зээлийн үлдэгдэл |            |
|---|-----------|------------------------------------|---------------------------------|-----------------|-----------------------------------|------------|
|   |           | Орон нутгийн хөрөнгөөс хуваарилсан | Зээлийн эргэн төлөлтөөс олгосон |                 | Зээлдэгчийн тоо                   | Мөнгөн дүн |
| 1 | 2012-2016 | 663.0                              | -                               | 28              | 26                                | 320.3      |
| 2 | 2017      | 560.0                              | -                               | 14              | 7                                 | 119.3      |
| 3 | 2018      | 395.0                              | 74.0                            | 29              | 10                                | 164.2      |
| 4 | 2019      | 207.0                              | 48.0                            | 21              | 17                                | 138.0      |
| 5 | 2020      | 480.0                              | 460.0                           | 55              | 49                                | 729.4      |
| 6 | 2021      | -                                  | 435.5                           | 25              | 25                                | 416.6      |
|   | ДҮН       | 2,305.0                            | 1,017.5                         | 172             | 134                               | 1,887.8    |

Эх сурвалж: “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аас ирүүлсэн судалгаа

Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг нийт 172 зээлдэгчид олгож, байнгын 177, түр 191, улирлын чанартай 178, нийт 546 ажлын байр бий болсон ба үйл ажиллагаа, салбарын чиглэлээр авч үзвэл 35.4 хувийг хөнгөн үйлдвэрлэлд, 29.2 хувийг бусад салбарт, 20.9 хувийг хүнсний үйлдвэрлэлд, 11.6 хувийг газар тариаланд, 2.9 хувийг мал аж ахуйн салбарт олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд бизнесийн инкубатор төвийн 2 давхар барилга, 2019 онд ахуйн үйлчилгээний төвийн 2 давхар барилгыг барьж “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д хүлээлгэн өгсөн байна.



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон 1,907.5 сая төгрөгийн өртөг бүхий бизнес инкубаторын зориулалт бүхий барилгад /Ажиллаг төв гэх/ тус корпораци үйл ажиллагаа явуулж, 30 өрөөг хувиараа бизнес эрхлэгч 27 иргэн, 3 аж ахуйн нэгж түрээслэн, хүнсний болон хөнгөн үйлдвэрлэл эрхэлж, байнгын 25, улирлын чанартай 3 ажлын байрыг шинээр бий болгосон байна.



Бизнес инкубатор төв нь хөнгөлөлттэй зээл авсан иргэдийг тодорхой хугацаанд тогтоосон хөнгөлөлттэй түрээсийн төлбөр төлж үйл ажиллагаа явуулан бойжуулан дараагийн зээл авсан иргэдийг оруулах зориулалтаар байгуулсан байна.

#### **Аудитын илрүүлэлт**

- Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.3<sup>11</sup> дахь заалтыг хэрэгжүүлж, арилжааны банкаар дамжуулан олгосон жижиг зээлийн эргэн төлөлтөд хяналт тавиагүй;

Аудитын явцад түрээслэгчдийн судалгааг гаргуулан авахад 8 түрээслэгч эхний жилдээ, 8 зээлдэгч 2 дахь жилдээ, 9 зээлдэгч 3 дахь жилдээ бол 5 зээлдэгч 4 дэх жилдээ ажиллаж байгаа ба инкубаторын зориулалтаар хэрхэн ашиглах, ямар хугацаанд үйл ажиллагаа явуулах зэргийг тодорхой тусгасан баримт бичиг байхгүй байна.

Ахуйн үйлчилгээний салбарын үйл ажиллагааг дэмжих, ажлын байргүй иргэдийг ажлын байраар хангах зорилгоор ашиглалтад орсон ахуйн үйлчилгээний төвд 18 өрөөг түрээслүүлсэн, үүнээс 10 хөнгөн үйлдвэрлэл явуулж, харин 8 өрөөг нь ахуйн үйлчилгээ эрхлээгүй 1 дэлгүүр, 5 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан ахуйн үйлчилгээний барилгыг зориулалтаар нь бүрэн ашиглах, бизнес инкубатор төвийг зориулалтын дагуу хэрхэн ашиглах баримт бичгийг боловсруулж мөрдөн, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үр өгөөжийг жигд, хүртээмжтэй хүргэх зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний удирдлагад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Засаг даргын санаачилгаар “Өвгөдийн шанд” ХХК-ийн захирал Б.Отгонбилэгээр ахлуулан “Жишиг өрх” төслийг хэрэгжүүлж, орон нутгийн ажилгүй, орлого багатай өрхүүдийг хамруулж, газар тариалан эрхлэх бүрэн боломжоор хангаснаар орлоготой болох нөхцөлийг бүрдүүлэн өгч, өрхийн хэрэгцээний 0.07 га газар, эрчим хүч, үр, бордоо, суулгацуудаар ханган хашаажуулан төмс, хүнсний ногоо, хамгаалагдсан хөрс буюу хүлэмж, гүн өрмийн худаг гаргах зэрэг ажлуудыг хийсэн байна.

<sup>11</sup> Зөвлөл нь ....хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын явц байдал, үүний дотор ХЭДС-ийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих;

Тус төслийн хүрээнд 2017 онд онд “Жишиг өрх” өрхийн аж ахуй төсөлд 46.0 сая, 2018 онд “Эрүүл жимсийг өөрийн хашаандаа”-I төсөлд 50.0 сая, 2019 онд “Эрүүл жимсийг өөрийн хашаандаа”-II төсөлд 50.0 сая, нийт 146.0 сая төгрөгийг 90 зорилтот өрхөд зарцуулжээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн А/250 дугаар “Жижиг өрхийн тариалалт” төслийн үйл ажиллагааг дүгнэх ажлын хэсгийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргаар ахлуулан, салбар бүрээс төлөөлөл оруулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дээрх ажлын хэсэг 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр 90 зорилтот өрхийн тариалалт хийсэн байдал, арчлалт, хамгаалалтыг шалгаж, ажлын хэсэг тус арга хэмжээг үр дүнтэй хэрэгжсэн гэж дүгнэж, илэрсэн 2 алдаанд холбогдох байгууллагуудад 3 зөвлөмжийг өгсөн байна.

1.3.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1<sup>12</sup>, 28.2<sup>13</sup>, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 02 дугаар тогтоолын дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2017 оны А/193 дугаар захирамжаар Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийг /цаашид зөвлөл гэх/ 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг албан тушаал, нэрээр томилсон, зөвлөлд байсан зарим албан тушаалд өөр хүн томилогдсон тул Баянхонгор аймгийн Засаг даргын 2017 оны А/700 дугаар захирамжаар зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 3.1<sup>14</sup>-т заасны дагуу 2021 онд шинэчлэн батлаагүй байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг албан тушаал, нэрээр баталж байгаа нь албан тушаалтнууд өөрчлөгдөж солигдож байгааг харгалзан цаашид зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан шийдвэрийг гаргахдаа хүний нэрээр биш албан тушаалаар нь батлах нь зүйтэй байна.

Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Баянхонгор аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн хэлтсийн дарга А.Өлзийжаргал ажиллаж, “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 3.1.1<sup>15</sup>-т заасны дагуу аймгийн Засаг дарга, СТСХ, НБХ-ийн дарга, дүрмийн 3.1.2<sup>16</sup>-т заасны дагуу аймгийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга, дэд дарга, аймгийн үйлдвэрчний эвлэлийн хяналтын хорооны дарга, дүрмийн 3.1.3<sup>17</sup>-т заасны дагуу МҮХАҮТ-ын Баянхонгор аймаг дахь салбар танхимын гишүүн, аймгийн ажил олгогч, эздийн холбооны төлөөлөл, ажил олгогчийн төлөөллийг оруулсан байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, эрхлэлтийн зөвлөл нь 2016 онд хуралдаагүй, 2020 онд нэг удаа хуралдсан боловч тогтоол гаргаагүй, жилийн эцсийн тайланг хэлэлцсэн, бусад онд 2-4 удаа хуралдсан байна.

Зөвлөл нь тухайн жилд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй, “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2-т заасанчлан зөвлөлд 9 чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байхад зөвлөл дүрмийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<sup>12</sup> Засгийн газар, ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийг байгуулж, ажиллуулна.

<sup>13</sup> Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн энэ хуулийн 28.1-д заасан гурван талын төлөөлөгчдийн тоо адил байна.

<sup>14</sup> Зөвлөлийн бүрэлдэхүүнийг талуудын санал болгосноор тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга 4 жилийн хугацаагаар батална. Зөвлөлийн дарга нь тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга байх бөгөөд гурван талын төлөөлөгчдийн тоо адил бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна.

<sup>15</sup> Төрийг төлөөлж Засаг дарга болон аймаг, нийслэл, дүүргийн боловсрол болон нийгмийн хөгжил, төсөв санхүүгийн байгууллагаас нийт гурван хүн;

<sup>16</sup> Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах орон нутгийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас гурван хүн;

<sup>17</sup> Ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах орон нутгийн ажил олгогчдын байгууллагаас гурван хүн;

### **Аудитын илрүүлэлт**

- Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.3<sup>18</sup> дахь заалтыг хэрэгжүүлж, арилжааны банкаар дамжуулан олгосон жижиг зээлийн эргэн төлөлтөд хяналт тавиагүй;
- Дүрмийн 2.2.4<sup>19</sup> дэх заалтын дагуу ХЭДС, орон нутгийн хөрөнгөөс хуваарилж жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК, улсын төсвөөс жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр арилжааны банкаар олгож байгаа хөнгөлөлттэй зээл зэрэг ажлын байр нэмэгдүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж буй арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийгээгүй;
- Дүрмийн 2.2.6<sup>20</sup> дэх заалтыг хэрэгжүүлээгүй, “Худалдаа аж үйлдвэрийн танхим” ТББ-аар 10.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгэсэн байхад хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаанд мэргэжлийн байгууллагыг оролцуулаагүй, судалгааны дүнг хэлэлцээгүй, эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаар иргэдэд мэдээлээгүй байна.
- Дүрмийн 2.2.8<sup>21</sup> дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс аймгийн хэмжээнд ажлын байр нэмэгдүүлэх эр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнг нэгтгэн гаргаагүй байна.
- Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь 2020 онд хуралдаагүй нь “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 3.5<sup>22</sup>-т заасантай нийцэхгүй байна.
- Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн өмнө ажиллаж байсан зарим гишүүдтэй уулзахад хуралдааны тэмдэглэл хэт товч, гишүүдийн хэлсэн үгийг тэмдэглэлд бүрэн бичээгүй, хуралд оролцогч нараар гарын үгийг зурж баталгаажуулаагүй;
- 2017 оны 12 дугаар сарын 06-ний өдрийн хуралдсан тэмдэглэл байхгүй, хуралд оролцсон зөвлөлийн гишүүнээс бусад албан тушаалтны нэрийг хурлын тэмдэглэлд бичээгүй байна.

Орон нутгийн ИТХ, ЗДТГ болон Хөдөлмөрийн хэлтсийг холбосон гүүр болсон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь хөдөлмөрийн асуудлаар орон нутагт хийгдэх бодлогыг тодорхойлох, байгууллагуудын харилцан уялдааг хангах, аймгийн хэмжээнд нэмэгдсэн ажлын байр, үр дүнг хэлэлцэн ажиллах шаардлагатай байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн жил бүрийн 3-4 дүгээр сард ХХҮЕГ-аас баталсан аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого, чиглэл, хамрагдах хүний тоо, төсөв батлах тухай хэлэлцсэн асуудал байгаа нь хурлын хэлэлцсэн асуудлын дийлэнх хувийг эзэлж байна.

Иймд “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг мөрдөж, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулж, гишүүд дүрэмд заасан эрх, үүргийг бүрэн биелүүлэх зөвлөмжийг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн даргад хүргүүлэв.

Баянхонгор Баянхонгор аймгийн ХХҮГ нь 2016-2021 онд ХНХЯ, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ХХҮЕГ, Баянхонгор аймгийн Статистикийн газар, аймгийн ЗДТГ-ын НБХ зэрэг газруудад бодлогын хэрэгжилтийг тайлагнадаг байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналтыг хэрэгжүүлж иржээ.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдэд 2016, 2017, 2018, 2020 онд тус хэлтсээс хийсэн хяналт

<sup>18</sup> Зөвлөл нь ....хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын явц байдал, үүний дотор ХЭДС-ийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих;

<sup>19</sup> Зөвлөл нь ....тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр, төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах

<sup>20</sup> Зөвлөл нь ....орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж, хэрэглэгчид, үйлчлүүлэгчид зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр хангах

<sup>21</sup> Зөвлөл нь ....тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон нөлөөлөлд хийсэн үнэлгээний тайланг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүрийн 1 дүгээр сард ирүүлж байх;

шалгалт хийсэн гэх боловч шалгалтын тайланг архивд байхгүй гэсэн албан бичгийг ХШҮХ-ээс ирүүлсэн болно.

Төрийн аудитын байгууллагад тус хэлтсээс 2019 онд хийсэн “Аймгийн дэд хөтөлбөрүүдийн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн талаар”, 2021 онд “Аймгийн дэд хөтөлбөрүүдийн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тайлан”, “Аймгийн дэд хөтөлбөрүүдийн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тухай зөвлөмж” зэрэг баримт материалын хуулбар хувийг ирүүлжээ.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2 дугаар хавсралтын дагуу дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийн дагуу хэрэгжилтийг гаргаагүй, ерөнхий байдлаар тайлагнасан байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2019 онд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” дэд хөтөлбөрийг 90%, “Илгээлтийн эзэн” дэд хөтөлбөрийг 90%, “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг 80%-тай хэрэгжсэн гэж дүгнэжээ.

Харин 2021 онд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” дэд хөтөлбөрийн хэрэгжилт эхний хагас жилд ирээгүй, 2021 онд төсөв батлагдаагүй тул төлөвлөгөө гаргаагүй гэж дүгнэсэн ба 2020 оныг хамруулан 2 жилээр үнэлээгүй байгаа нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1 дүгээр хавсралтын дагуу дүгнээгүй, “Илгээлтийн эзэн”, “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг үнэлээгүй байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг биелүүлж ажиллаагүй байна.

Иймд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1, 2 дугаар хавсралтын дагуу дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж тайлагнаж ирүүлэх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэв.

## **БҮЛЭГ 2. ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙРЫГ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧЭЭС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЛЭЭР ТАЙЛАН МЭДЭЭГ НЭГТГЭН ТАЙЛАГНАЖ БАЙГАА НЬ БОДИТ БАЙДЛААС ЗӨРҮҮТЭЙ, АЖИЛТНЫ ЦАЛИНГ НИЙГМИЙН ДААТГАЛД МЭДЭЭЛЭЭГҮЙ НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ БИЙ БОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ БУУРУУЛАХ ГОЛ НӨХЦӨЛ БОЛЖ БАЙНА.**

### **2.1. Баянхонгор аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс ажил орлогогүй иргэдээс судалгаа авч, дүн шинжилгээ хийх, тэднийг мэдээллээр хангах ажил хангалтгүй байна.**

2.1.1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өсч байгаа хэдий ч байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалгын тоо буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний MNS6620:2016 стандартыг нэвтрүүлэн ганцаарчилсан зөвлөгөөний өрөө, бүлгийн сургалтын өрөөг стандартын дагуу Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр GFA консалтинг группын хэрэгжүүлж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хөрөнгө оруулалт хийж “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний загвар төв”-ийг

2019 онд нээн, нэг гэрээт ажилтныг аймгийн ЗДТГ-аас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжулан ажиллуулж байна.

### Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ

Тус үйлчилгээнд 2016-2021 онд нийт 10,949 иргэд хамрагдсанаас бүлгийн сургалт зөвлөгөөнд 7,668, ганцаарчилсан зөвлөгөөнд 3,281 иргэн хамрагдаж 86.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 6. АМЧБОЗҮ-ний судалгаа (сая төгрөгөөр)

| Он   | Зарцуулсан хөрөнгө | Ганцаарчилсан зөвлөгөө |         | Бүлгийн сургалт, зөвлөгөө |         | Хамрагдсан иргэдийн тоо |         |
|------|--------------------|------------------------|---------|---------------------------|---------|-------------------------|---------|
|      |                    | Нийт                   | эмэгтэй | Нийт                      | эмэгтэй | Нийт                    | эмэгтэй |
| 2016 | 17.2               | 60                     | 25      | 1,627                     | 1,154   | 1,687                   | 1,179   |
| 2017 | 11.1               | 535                    | 308     | 806                       | 465     | 1,341                   | 773     |
| 2018 | 12.5               | 620                    | 406     | 988                       | 665     | 1,608                   | 1,071   |
| 2019 | 14.4               | 630                    | 346     | 1,000                     | 584     | 1,630                   | 930     |
| 2020 | 12.5               | 702                    | 394     | 1,013                     | 628     | 1,715                   | 1,022   |
| 2021 | 18.5               | 734                    | 488     | 2,234                     | 1,262   | 2,968                   | 1,750   |
| Дүн  | 86.2               | 3,281                  | 1,967   | 7,668                     | 4,758   | 10,949                  | 6,725   |

Эх сурвалж ХХҮГ-ын жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан

Ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд 3,281 хүн хамрагдсанаас ажлын байрны дэмжлэг олгох хөтөлбөрт 41.5 хувь, ажилд зуучилсан 49.0 хувь, бусад арга хэмжээнд 9.5 хувь тус тус хамрагдсан байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг хэсэг бүлгээр зохион байгуулах арга хэмжээнд 7,668 хүн хамрагдсан бөгөөд үүнээс ажил хайгч 1812, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид 4518, ажил олоход хүндрэлтэй иргэд 426, их дээд сургууль төгсөгч, мэргэжлийн боловсрол, сургалт үйлдвэрлэлийг төгсөгч 755, бусад 157 хүн хамрагдсан байна.

### Ажилд зуучлах үйлчилгээ

Ажилд зуучлах үйлчилгээнд 2016-2021 онд 7,991 хүн хамрагдаж 49.4 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 7. Ажилд зуучлагдсан иргэд, зарцуулсан төсвийн судалгаа (сая төгрөгөөр)

| Он   | ААН байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалга | Ажилд зуучлагдсан иргэд | Үүнээс                           |                             | Зарцуулсан төсөв | Ажилд зуучилсан хувь |
|------|--------------------------------------------------|-------------------------|----------------------------------|-----------------------------|------------------|----------------------|
|      |                                                  |                         | Байнгын ажлын байранд хамрагдсан | Түр ажлын байранд зуучласан |                  |                      |
| 2016 | 1,029                                            | 933                     | 494                              | 439                         | 0.4              | 90.6                 |
| 2017 | 2,121                                            | 1,754                   | 1088                             | 666                         | 10.2             | 82.6                 |
| 2018 | 1,688                                            | 1,312                   | 943                              | 369                         | 10.3             | 77.7                 |
| 2019 | 2,076                                            | 1,473                   | 917                              | 556                         | 10.3             | 70.9                 |
| 2020 | 1,520                                            | 1,276                   | 715                              | 561                         | 9.5              | 83.9                 |
| 2021 | 1,476                                            | 1,243                   | 722                              | 521                         | 8.6              | 84.2                 |
| нийт | 9,910                                            | 7,991                   | 4879                             | 3112                        | 49.4             | 80.6                 |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ХХҮГ-ын статистик мэдээ

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн системд аж ахуй нэгж байгууллагуудаас 9,910 ажлын байрны захиалга ирж, 80.6 хувь буюу 7,991 хүнийг ажилд зуучилснаас байнгын ажлын байранд 61.1 хувь буюу 4,879 хүн, түр ажлын байранд 38.9 хувь буюу 3,112 хүн зуучлагдсан байна.


Хүснэгт 6, 7-оос харахад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өсч байгаа хэдий ч байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалгын тоо буурсан үзүүлэлттэй байгаад аймгийн ХХҮГ анхаарч ажил олгогч нар сургалт явуулсан чиглэл, сургалтад хамрагдсан иргэдийн мэдээллийг хүргэж, ажилд зуучлах үйлчилгээг эрчимжүүлэх нь зүйтэй байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага 25-аас дээш орон тоотой аж ахуйн нэгж, байгууллага нь 25 ажилтан тутамд 1 хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулахаар заасан байхад ХХҮГ-ын хяналтаар 2021 оны байдлаар 85 аж ахуйн нэгж төлбөрийн орлогыг санд бүрэн оруулаагүй байгаа ба энэ нь орлогыг санд төвлөрүүлэхээс илүүтэй тухайн иргэдийг байнгын ажлын байранд зуучилж ажиллуулах нь нэн тэргүүний ач холбогдолтой байна.

2.1.2. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн LMIS программд ХНХЯ-ны харьяа байгууллагуудын мэдээлэл бүрэн холбогдоогүйгээс ашиглалт хангалтгүй, хөгжүүлэлтийг хийх шаардлагатай байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн яамны харьяа байгууллагуудын үйл ажиллагааг илүү хурдан, шуурхай, нээлттэй болгож, хөдөлмөрийн зах зээл дээрх мэдээллийг нэгдсэн санд төвлөрүүлэн дүн шинжилгээ хийх зорилгоор LMIS хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийг 2014 оноос хойш ашиглаж байна.

Тус системийн 2013 онд гаргасан гарын авлагад системийн зорилгыг “Хөдөлмөрийн яам болон түүний харьяа байгууллагуудыг төвлөрсөн мэдээллийн сантай болгосноор байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах” гэж тодорхойлжээ.



Тус системд 7 модул багтсан ба одоогийн байдлаар хөдөлмөр зуучлал, АМЧБО үйлчилгээ модулаас бусад 5 модул ашиглалтгүй байна.

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын мэргэжилтний эрхээр системд хандахад 2022 оны 04 дүгээр сарын 29-ний байдлаар LMIS

системд 873 иргэн бүртгэлтэй, үүнээс 470 нь эмэгтэй байна.

Аудитын явцад LMIS системийн ашиглалттай танилцахад дараах зүйлийг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

#### Анхаарах асуудал

1. Ажил хайгч иргэн системд бүртгүүлж идэвхтэй төлөвт орж, анх бүртгүүлснээс хойш 3 сарын дотор ажилд ороогүй бол идэвхгүй төлөвт шилждэг ба хариуцсан мэргэжилтэн системд тохиргоо хийснээр дахин идэвхтэй төлөвт шилждэг байна. Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсээс авсан мэдээлэлд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2018 онд 1287, 2019 онд 416, 2020 онд 1479 байгааг тодруулахад идэвхгүй болсон ажил хайгчдыг идэвхтэй болгох ажлыг системд хийгээгүйтэй холбоотой байгаа тул систем дэх гар ажиллагааг багасган, ажил хайгч иргэн ажилд зуучлагдах хүртэлх хугацаанд идэвхгүй төлөвт шилжихгүй шинэчлэлтийг хийх;
2. LMIS системийн давуу талыг УБЕГ, ТЕГ, НДЕГ-тай холбогдож, мэдээллийн үнэн бодит байдлыг шалгаснаар мэдээллийн давхардал үүсэхээс сэргийлнэ гэж системийн давуу талыг гарын авлагад тодорхойлсон байна. Гэвч Улсын бүртгэлийн Ерөнхий газарт шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжийг excel жагсаалтаар ХХҮГ-т хандсанаар системийн баазад ХХҮГ нэмж бүртгэдэг, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын мэдээлэлд тухайн иргэн ямар байгууллагад ямар хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлснийг харах боломжтой, харин аж ахуйн нэгжийн хувьд нийгмийн даатгал төлж байгаа хэдэн ажилтан байгааг харах боломжгүй байна.

3. Тус системд бүртгэлтэй иргэнийг ямар үйлчилгээнд хэдэн онд хамрагдаж, санхүүгийн дэмжлэг авсныг нэгтгэн авч, шүүх боломжгүй байна.
4. Системд нэвтрэхэд нэвтрэлт удаан, гацалт их байна.

Иймд хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системд Хөдөлмөрийн яамны харьяа байгууллагуудын мэдээллийг түргэн, шуурхай авах, иргэний талаарх мэдээллийг системээс дурын цаг хугацаагаар сонгон авах хөгжүүлэлтийг хийж, системийн ашиглалтыг иж бүрэн болгох зөвлөмжийг ҮАГ-аар дамжуулан ХХҮЕГ-т өгөх нь зүйтэй тул саналыг ҮАГ-т хүргүүлэв.

2.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг бодитой тооцохгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.2<sup>23</sup>-т нийтлэг үйлчилгээнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах, ажилгүйдлийн тэтгэмж олгох, нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах, бусад үйлчилгээг хамааруулахаар заасан байна.

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн хэлтсээс 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ болох хуулийн 6.2.1, 6.2.2 дахь заалтад заасан үйлчилгээнд жилд дунджаар 3,157 иргэн хамрагдаж, 18.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 8. Нийтлэг үйлчилгээ авсан иргэд, зарцуулсан хөрөнгийн судалгаа (сая төгрөгөөр)

| Он      | Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо |                         | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдсан тоо |                        |                           |                         |
|---------|---------------------------------------------------|-------------------------|---------------------------------------------------------------|------------------------|---------------------------|-------------------------|
|         | Зарцуулсан хөрөнгө                                | Хамрагдсан иргэдийн тоо | Зарцуулсан хөрөнгө                                            | Ганцаарчилсан зөвлөгөө | Бүлгийн сургалт, зөвлөгөө | Хамрагдсан иргэдийн тоо |
| 2016 он | 0.4                                               | 933                     | 17                                                            | 60                     | 1,627                     | 1,687                   |
| 2017 он | 10.2                                              | 1,754                   | 11                                                            | 535                    | 806                       | 1,341                   |
| 2018 он | 10.3                                              | 1,312                   | 13                                                            | 620                    | 988                       | 1,608                   |
| 2019 он | 10.3                                              | 1,473                   | 14                                                            | 630                    | 1,000                     | 1,630                   |
| 2020 он | 9.5                                               | 1,276                   | 12                                                            | 702                    | 1,013                     | 1,715                   |
| 2021 он | 8.6                                               | 1,243                   | 18                                                            | 734                    | 2,234                     | 2,968                   |
| Дүн     | 49                                                | 7,991                   | 86                                                            | 3,281                  | 7,668                     | 10,949                  |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ХХҮГ-ын статистик мэдээ

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн хэлтсээс хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан төсвийн үр ашгийг хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна.

Сургалт, зөвлөгөө, мэдээлэлд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ болон бусад арга хэмжээнд хамрагдсан байдлаар авч үзвэл дунджаар нь 52.3 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан байна.

Хүснэгт 9. “Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан хувь”

|                                                          | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | Дундаж      |
|----------------------------------------------------------|------|------|------|------|------|------|-------------|
| Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хувь | 51.1 | 50.2 | 54.0 | 58.4 | 50.3 | 50.3 | <b>52.3</b> |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны үйл ажиллагааны тайлан

Дээрх шинжилгээнүүдийн дүнд нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэд нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг бүрэн авч чадахгүй нийтлэг үйлчилгээний үр дүн харагдахгүй байгааг харуулж байна.

<sup>23</sup> 6.2.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

6.2.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

6.2.2.ажилд зуучлах;

6.2.3.ажилгүйдлийн тэтгэмж олгох;

6.2.4.нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;

6.2.5.бусад үйлчилгээ.

## 2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд ажлын байр нэмэгдэж байгаа ч ажилгүйдэл өссөн байна.

2.2.1. Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийн санхүүжилтээр олгосон хөнгөлөлттэй зээлийг олгосноор ажлын байрыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмрийг оруулсан байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан /цаашид ЖДҮХС гэх/-аас 2017, 2018 онд санхүүжилт олгоогүй ба Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар ЖДҮХС-аас Баянхонгор аймагт 2019 онд 1,000.0, 2020 онд 500.0 сая, нийт 1,500.0 сая төгрөг хуваарилсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан аймгийн жижиг дунд үйлдвэрийн /цаашид ЖДҮ гэх/-ийн төслийг сонгон шалгаруулж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий, хяналт тавих дэд хороог томилж, ирүүлсэн төслийг хороо хэлэлцэн баталж, дэмжигдсэн төслийн жагсаалтыг аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлж, улмаар арилжааны банкнуудад хүргүүлдэг байна.

Дээрх төслөөс арилжааны банкнаас тавьсан шаардлагыг хангасан төслүүдэд ХХААХҮС-ын 2019.05.14-ний өдрийн А/146 дугаар тушаалаар баталсан хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийн дагуу зээлийн хүүг жилийн 8 хувиас ихгүй байх, 5 хүртэл жилийн хугацаатай олгож, үндсэн зээлээс эхний 12 сарын хугацаанд чөлөөлөхөөр заасны дагуу Хаан банк 5.4%, Хас банк 5.6%, Төрийн банк 5.8%-ийн хүүтэй, 36-60 сарын хугацаатай олгож, эхний 12 сарын хугацаанд үндсэн зээлээс чөлөөлөгдсөн байна.

Нийт зээлийн 85.3 хувь буюу 581.0 сая төгрөгийг Хаан банк олгосон бөгөөд ЖДҮХС-аас арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийн үр дүнд 2019 онд 70, 2022 онд 22 байнгын ажлын байр бий болжээ.

Хүснэгт 10. ЖДҮХС-аас олгосон зээлийн судалгаа (сая төгрөгөөр)

| Ангилал | Хас банк    |            | Хаан банк   |            | Төрийн банк |            | Нийт олгосон |            |
|---------|-------------|------------|-------------|------------|-------------|------------|--------------|------------|
|         | Төслийн тоо | Мөнгөн дүн | Төслийн тоо | Мөнгөн дүн | Төслийн тоо | Мөнгөн дүн | Төслийн тоо  | Мөнгөн дүн |
| Иргэн   | 1           | 20.0       | 14          | 406.0      | 2           | 40.0       | 17           | 466.0      |
| ААН     | 2           | 40.0       | 7           | 175.0      | 0           | 0.0        | 9            | 215.0      |
| ДҮН     | 3           | 60.0       | 21          | 581.0      | 2           | 40.0       | 26           | 681.0      |

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь ТАГ-аас “ЖДҮХС-аас олгосон зээлийн зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ХХААХҮЯ-ны ЖДҮХС-аас батлагдаж, Баянхонгор аймагт 2019 онд хуваарилсан 1,000.0 сая төгрөгийн санхүүжүүлэх эх үүсвэрээс арилжааны 3 банкаар дамжуулан нийт 681.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, үлдэгдэл 319.0 сая төгрөгийг олгоогүй, 2020 онд 500.0 сая төгрөг хуваарилж, ЖДҮХС-аар дамжуулан 473.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, 27.0 сая төгрөгийг олгоогүй нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид хөнгөлөлттэй зээл авч бизнесээ өргөжүүлэх боломжийг бүрэн ашиглаагүй байна.

Сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд зориулж, Баянхонгор аймгийн 20 сумын Сум хөгжүүлэх сангаас 2016-2021 онд 842 иргэнд 5,009.5 сая, 30 аж ахуйн нэгж, байгууллагад 470,0 сая, нийт 5,479.5 сая төгрөгийг олгож, байнгын 582, түр 493 ажлын байрыг бий болгосон байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хяналт шалгалтын байгууллагаас тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй, үүний улмаас шүүх хяналтын байгууллагуудад асуудлыг шилжүүлж, шүүхийн

шийдвэр гүйцэтгэх газарт ажиллагаа хийгдэх асуудал нийтлэг байсан. Иймд төрийн аудитын байгууллагаас Сум хөгжүүлэх сангийн зээлийг Монгол банкны мэдээллийн нэгдсэн санд холбох зөвлөмжийг холбогдох газруудад жил дараалан өгсний үр дүнд 2020 оны 3 дугаар сараас эхлэн Сум хөгжүүлэх сангийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн нэгдсэн санд холбосноор хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлт сайжирсан байна.

“Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилт”-ын хөтөлбөрийн хүрээнд “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ”-ний хүрээнд ХХҮЕГ-ын дарга, арилжааны төв банкны захирлуудтай байгуулсан гэрээний дагуу жил бүр аймгийн эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо, ажилгүй иргэдийн тоо, ядуу иргэдийн тоо, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг хүссэн иргэний тоо гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан аймагт жижиг зээлийн эх үүсвэрийг хуваарилсан байна.

| Банкны нэр  | Зээлдэгчийн тоо | Зээлийн дүн | Хадгалагдсан ажлын байр | Шинээр бий болсон ажлын байр |
|-------------|-----------------|-------------|-------------------------|------------------------------|
| Төрийн банк | 146             | 459.2       | 259                     | 0                            |
| Хаан банк   | 148             | 1,218.0     | 149                     | 142                          |
| Голомт банк | 44              | 477.7       | 47                      | 80                           |
| ДҮН         | 338             | 2154.9      | 455                     | 222                          |

“Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилт”-ын хөтөлбөрийн хүрээнд жижиг зээлийг арилжааны 3 банкаар дамжуулан 2016-2021 онд 338 зээлдэгчид 2,154.9 сая төгрөгийн зээлийг олгож, 455 ажлын байрыг хадгалж, 222 ажлын байр шинээр бий болгожээ.

Хөнгөлөлттэй зээлийг 24 хүртэл сарын хугацаатай, сарын 0.2 хувийн хүүтэй, эхний 2-6 сарын хугацаанд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлж, иргэнд 10.0 сая хүртэлх, аж ахуйн нэгжид 20.0 хүртэлх сая төгрөгийн зээлийг олгох нөхцөлтэй байна.

ХХҮЕГ-ын дарга, арилжааны төв банкны захирлуудтай байгуулсан гэрээний 2.6<sup>24</sup>, 3.10<sup>25</sup>, 6.1<sup>26</sup>-т гэсэн заалтууд хэрэгжээгүй, арилжааны банк мэдээллийг ирүүлээгүйгээс Баянхонгор аймгийн ХХҮГ-т жижиг зээлийн мэдээллийн сан байхгүй, гэрээг дүгнэж ажиллаагүй байна. Иймд цаашид мэдээллийг авч, гэрээг дүгнэх, сан үүсгэн, цаасаар болон цахимаар хадгалах нь зүйтэй байна.

ХХҮГ-аас аудитад шаардлагатай жижиг зээлийн талаарх баримт материалыг ирүүлээгүй болно. Иймд цаашид Хөдөлмөрийн хэлтсийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, дотоод хяналтыг сайжруулахыг газрын даргад зөвлөв.

#### **Аудитын илрүүлэлт**

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр зээл, тусламж, бүх төрлийн сан, олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд тухайн жилд бий болсон ажлын байрны судалгааг аймгийн хэмжээнд нэгтгэн дүгнээгүй байна.

Иймд аудитын баг аудитын явцад хийсэн судалгаагаар Баянхонгор аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2015-2021 онд зарцуулсан хөрөнгийн үр дүнг нэгтгэн гаргасан судалгаагаар аймгийн хэмжээнд 35,039 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан нийт 11,948.5 сая төгрөгийг зарцуулсны үр дүнд 7,214 байнгын, 7,903 түр ажлын байр бий болсон байна.

<sup>24</sup> Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь ажлын гэрээг үндэслэн зээлдэгчийн талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ”

<sup>25</sup> Банк нь зээлийн эх үүсвэрийн сар тутмын ашиглалтын мэдээг ХХҮЕГ болон аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад дараа сарын 5-ны дотор хавсралт загварын дагуу хүргүүлнэ.

<sup>26</sup> Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон банкны салбарын хамтын ажиллагаа: Зээл олгох үйл ажиллагаа, зээлийн эх үүсвэрийн ашиглалт, эргэн төлөлт, гэрээний биелэлтийг талууд жил тутамд дүгнэнэ.

Цаашид тухайн жилд бий болсон бий болох ажлын байрыг төлөвлөж, зарцуулсан хөрөнгийн үр дүн, бий болсон ажлын байрны тоог үнэн зөв гарган, нэгтгэн, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах нь зүйтэй.

2.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд жил бүр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас санхүүгийн тайлангийн аудит хийдэг, 2016-2021 онд “Зөрчилгүй” санал дүгнэлт авч, 982.2 сая төгрөгийн 15 зөрчил илэрснээс 66.7 хувь буюу 603.1 сая төгрөгийн 10 зөрчилд зөвлөмж өгч, 20 хувь буюу 96.0 сая төгрөгийн албан шаардлагыг өгч, 13.3 хувь буюу 283.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

Хүснэгт 11. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл (сая төгрөгөөр)

| Он         | Санал дүгнэлтийн хэлбэр | Нийт зөрчлийн дүн |              | Үүнээс төлбөрийн акт |              | Албан шаардлага |             | Зөвлөмж   |              | Залруулга |            |
|------------|-------------------------|-------------------|--------------|----------------------|--------------|-----------------|-------------|-----------|--------------|-----------|------------|
|            |                         | Тоо               | Мөнгөн дүн   | Тоо                  | Мөнгөн дүн   | Тоо             | Мөнгөн дүн  | Тоо       | Мөнгөн дүн   | Тоо       | Мөнгөн дүн |
| 2016       | Зөрчилгүй               | 2                 | 0.0          | 0                    | 0.0          | 0               | 0.0         | 2         | 0.0          | 0         | 0          |
| 2017       | Зөрчилгүй               | 2                 | 96.0         | 0                    | 0.0          | 1               | 96.0        | 1         | 0.0          | 0         | 0          |
| 2018       | Зөрчилгүй               | 0                 | 0.0          | 0                    | 0.0          | 0               | 0.0         | 0         | 0.0          | 0         | 0          |
| 2019       | Зөрчилгүй               | 2                 | 154.5        | 0                    | 0.0          | 0               | 0.0         | 2         | 154.5        | 0         | 0          |
| 2020       | Зөрчилгүй               | 6                 | 319.3        | 1                    | 0.7          | 1               | 0.0         | 4         | 318.6        | 0         | 0          |
| 2021       | Зөрчилгүй               | 3                 | 412.4        | 1                    | 282.4        | 1               | 0.0         | 1         | 130.0        | 0         | 0          |
| <b>ДҮН</b> |                         | <b>15</b>         | <b>982.2</b> | <b>2</b>             | <b>283.1</b> | <b>3</b>        | <b>96.0</b> | <b>10</b> | <b>603.1</b> | <b>0</b>  | <b>0</b>   |

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын Захиргаа, хяналтын хэлтсээс ирүүлсэн тайлангаас авч үзэхэд 2020 оноос бусад онд жил бүр дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Нийт 10 чиглэлээр дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тус онуудад 36 зөвлөмж өгч, хэрэгжилтийг 80-100 хувиар дүгнэсэн байна.

Дотоод хяналт шалгалтаар мэргэжилтнүүд төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд дутуу бүртгэсэн, төсөл, хөтөлбөр, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж явцын болон гүйцэтгэлийн тайлан ирүүлээгүй, ажлын байр бий болгосон хэдий ч нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хангалтгүй, ажил хайгч иргэний бүртгэл мэдээллийг дутуу авсан зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Хяналтын тайлангаас дүгнэхэд санхүүгийн дэмжлэг авсан иргэдэд хяналт тавихдаа төсөлд заасан үйл ажиллагааны чиглэлийг харгалзан шалгалт хийх улирлыг сонгон, иргэдийг шалгалтад бүрэн хамруулах, нас барсан иргэдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгийг хэрхэн шийдвэрлэх, сар бүр тайлан гаргаж ирүүлэх асуудлыг улирлаар, хагас, бүтэн жилээр болгон өөрчлөлт оруулах зэрэгт анхаарч ажиллах нь зүйтэй байна.

ХХҮЕГ-ын Хяналт мониторингийн газраас 2016, 2019 онд хяналт шалгалт хийж, 2016 онд 3, 2019 онд 6 зөвлөмжийг ХЭДС-тай холбоотой өгсөн, Захиргаа, хяналтын хэлтсээс 2016 оны зөвлөмжийн хэрэгжилтийг 88.2%, 2019 оны хэрэгжилтийг 75.0% дүгнэжээ.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон ажлын байрыг газар дээр нь шалгаж, нийгмийн даатгалын мэдээлэлд тулгуурлан бодитоор тайлагнаж, үнэлээгүй, бий болсон ажлын байрны тоог иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн тоогоор мэдээлдэг боловч

шинээр бий болсон ажлын байранд ажиллаж буй иргэний нийгмийн даатгалыг төлдөггүйгээс ажлын байрны тоо үнэн зөв мэдээлэгдэхгүй байна.

Үүнээс үзэхэд мэдээ тайланд бий болсон ажлын байрыг төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн мэдээллийг авч, бодит байдлаас зөрүүтэй тайлагнаж, үнэлж байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох арга хэмжээний үр дүн бодит байдалтай нийцэхгүй байх гол нөхцөл болж байна.

2.2.3. “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг баталсан хэдий ч хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгаас төсөв батлаагүйгээс ажил хийгдээгүй байна.

Баянхонгор аймагт ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 50.7 хувийг эмэгтэйчүүд эзэлсэн байна.

Баянхонгор аймгийн эмэгтэйчүүдийн эрүүл аюулгүй амьдрах, хөдөлмөр эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг зорилго бүхий “Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 141 дүгээр тогтоолоор баталж, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлого, амьжиргааг сайжруулж, ядуурлаас гаргах” зорилтын хүрээнд 16 үйл ажиллагааг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийн 2017-2021 онд хэрэгжилтийн нэгтгэлийг гаргахдаа дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 2018 онд 3.6 сая, 2019 онд 2.0 сая, 2020 онд 5.0 сая, нийт 10.6 сая төгрөгийг баталж, олгосноор 114 эмэгтэй түр болон байнгын ажлын байртай болсон гэж тайлагнажээ. Гэвч жил бүрийн тайлангийн хэрэгжилтийг шалгахад дээрх мэдээлэл нь нотлогдохгүй байгаа тул мэдээллийн үнэн зөв байдалд анхаарч ажиллахыг аймгийн ЗДТГ-ын даргад зөвлөв.

Баянхонгор аймгийн ГБХЗХГ-аас гаргасан “Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 2018-2021 он тус бүрээр гаргасан, хэрэгжилтэд дэвшүүлсэн 16 зорилтын хүрээнд эдгээр онд ямар ажлууд хийгдэж, үр дүн хэрхэн гарсан талаар нэгтгэн дүгнээгүй, аймгийн дэд хөтөлбөрийн үр дүнг хэлэлцээгүй байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ДХШҮДАХ-ээс 2019 онд тус хөтөлбөрийн үр дүнг 80%, 2021 оны эхний хагас жилд хөтөлбөрийг үнэлээгүй байна.

## **2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг ХЭДС-д бүрэн төвлөрүүлсэн байна.**

2.3.1. Баянхонгор аймгийн ХЭДС-д 2016-2021 онд зээлийн эргэн төлөлтөөс 1,448.8 сая, ХБИ ажиллуулаагүй орлогоос 173.5 сая төгрөг төвлөрснийг ХЭДС-д нэгдсэн санд бүрэн төвлөрүүлсэн боловч эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн авлагын нийт 31.0 хувь буюу 340.6 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн байна.

ХЭДС-аас 2014 хойш 1,255 хүнд 3,309.1 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгож 507 хүний 1,745.3 сая төгрөг төлөгдсөн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 748 хүний 1,563.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлагын үлдэгдлээс хугацаа хэтэрсэн авлага нь 232 хүний 340.6 сая төгрөгийн авлага байна.

**Хүснэгт 12. Авлагын судалгаа (сая төгрөгөөр)**

| №        | Хөтөлбөрийн нэр                                                                             | Олгосон санхүүгийн дэмжлэг |         | Төлсөн дүн |         | 2021.12.31-ээрх үлдэгдэл /авлага/ |         | Хугацаа хэтэрсэн |       |
|----------|---------------------------------------------------------------------------------------------|----------------------------|---------|------------|---------|-----------------------------------|---------|------------------|-------|
|          |                                                                                             | хүний тоо                  | дүн     | хүний тоо  | дүн     | хүний тоо                         | дүн     | хүний тоо        | дүн   |
| 1        | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих                       | 440                        | 920.5   | 159        | 322.2   | 281                               | 598.3   | 66               | 78.0  |
| 2        | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих                                     | 132                        | 95.0    | 17         | 48.7    | 115                               | 146.3   | 45               | 52.3  |
| 3        | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих                                                          | 570                        | 1,614.1 | 283        | 1,088.5 | 287                               | 525.6   | 94               | 113.4 |
| 4        | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ                                                         | 58                         | 114.5   | 27         | 50.5    | 31                                | 64.1    | 9                | 10.4  |
| 5        | Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл | 11                         | 200.0   | 7          | 166.5   | 4                                 | 33.5    | 4                | 33.5  |
| 6        | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих                                      | 44                         | 265.0   | 14         | 69.0    | 30                                | 196.0   | 14               | 53.0  |
| Нийт дүн |                                                                                             | 1,255                      | 3,309.1 | 507        | 1,745.3 | 748                               | 1,563.8 | 232              | 340.6 |

Эх сурвалж: ХЭДС-ийн мэдээ, тайлан

Дээрх хүснэгтээс харахад авлагыг хугацаанд нь төвлөрүүлээгүй нь Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1<sup>27</sup> заалтыг аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн хэлтэс бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй 56 хүний 58.2 сая төгрөгийг эргүүлэн төлүүлэх асуудлыг хуулийн байгууллагад 2021 оны 12 дугаар сараас өмнө шилжүүлсэн, үлдэх 176 хүний 282.4 сая төгрөгийг төлүүлэх төлбөрийн актыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн ХЭДС-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон байна.

Дээрх хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлд нас барсан 6 зээлдэгчийн 9.5 сая төгрөгийн үлдэгдэл байгаа бөгөөд хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг зөвлөв.

ХЭДС-д 2016-2021 онд зээлийн эргэн төлөлтийн орлого 1398 хүний 1,448.8 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний 58 хүний 173.5 сая, нийт 1,622.3 сая төгрөг төвлөрсөн бөгөөд үүнийг ХЭДС-ийн төв санд бүрэн төвлөрүүлсэн байна.

Дээрх төвлөрүүлсэн орлогоос орон нутгийн хөрөнгөөр санхүүжсэн малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөлтийн 10.2 сая төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлсэн тул 2022 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх зөвлөмжийг аймгийн ХХҮГ-т хүргүүлэв.

**Хүснэгт 13. ХБИ ажиллуулаагүй орлогын судалгаа (сая төгрөгөөр)**

| он   | Зээлийн эргэн төлөлт |         | ХБИ ажиллуулаагүй орлого |        | Дүн       |         | Татан төвлөрүүлсэн дүн |         | Зөрүү     |        |
|------|----------------------|---------|--------------------------|--------|-----------|---------|------------------------|---------|-----------|--------|
|      | хүний тоо            | орлого  | хүний тоо                | орлого | хүний тоо | орлого  | хүний тоо              | орлого  | хүний тоо | орлого |
| 2016 | 48                   | 49.8    | 2                        | 1.0    | 50        | 50.8    | 50                     | 50.8    | 0         | 0.0    |
| 2017 | 118                  | 141.4   | 2                        | 1.1    | 120       | 142.4   | 120                    | 142.4   | 0         | 0.0    |
| 2018 | 248                  | 242.8   | 5                        | 2.9    | 253       | 245.6   | 253                    | 245.6   | 0         | 0.0    |
| 2019 | 211                  | 363.8   | 7                        | 4.8    | 218       | 368.6   | 218                    | 368.6   | 0         | 0.0    |
| 2020 | 458                  | 371.2   | 40                       | 156.3  | 498       | 527.5   | 498                    | 527.5   | 0         | 0.0    |
| 2021 | 315                  | 279.9   | 2                        | 7.4    | 317       | 287.3   | 317                    | 287.3   | 0         | 0.0    |
| дүн  | 1398                 | 1,448.8 | 58                       | 173.5  | 1456      | 1,622.3 | 1456                   | 1,622.3 | 0         | 0.0    |

Эх сурвалж: ХЭДС-ийн мэдээ, тайлан

2.3.2. ХХҮЕГ-ын даргын тушаалаар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн төсвийн хуваарийг баталж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

<sup>27</sup> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг хөтлөх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гүйцэтгэнэ.

ХЭҮЗ-ийн 2015 оны 9 дүгээр тогтоолоор 2016 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүд, 2017 оны 01 дүгээр тогтоолоор 2017-2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүд, 2019 оны 01 дүгээр тогтоолоор 2019-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүд, 2021 оны 01 дүгээр тогтоолоор 2021-2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлсэн байна. Үүнд

1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
6. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр
7. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой зорилтот төслийн санхүүжилт /200 хүртэл сая төгрөг/
8. Хүүхэд хамгаалагч төсөл

### 1.Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд:

Иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад хамруулж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд 1239 хүнд 267.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1351 хүнд 210.1 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөсөн зардлын 78.4 хувийг зарцуулсан байна.

Хүснэгт 14. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

| Он   | Төлөвлөгөө          |                   | Гүйцэтгэл            |                    | Хувь                 |                    |
|------|---------------------|-------------------|----------------------|--------------------|----------------------|--------------------|
|      | Хамрагдах хүний тоо | Зарцуулах хөрөнгө | хамрагдсан хүний тоо | Зарцуулсан хөрөнгө | хамрагдсан хүний тоо | Зарцуулсан хөрөнгө |
| 2016 | 184                 | 114.2             | 188                  | 70.7               | 102.2                | 61.9               |
| 2017 | 233                 | 44.5              | 306                  | 44.3               | 131.3                | 99.6               |
| 2018 | 172                 | 31.4              | 188                  | 26.8               | 109.3                | 85.4               |
| 2019 | 172                 | 31.4              | 188                  | 29.6               | 109.3                | 94.2               |
| 2020 | 145                 | 20.1              | 140                  | 12.5               | 96.6                 | 62.2               |
| 2021 | 333                 | 26.4              | 341                  | 26.3               | 102.4                | 99.7               |
| Дүн  | 1239                | 267.9             | 1351                 | 210.1              | 109.0                | 78.4               |

Эх сурвалж: ХЭДС-ийн мэдээ, тайлан

Тухайн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээгээр авч үзвэл хөдөлмөр бэлтгэх сургалтад 2016-2021 онд 380 хүн хамрагдаж 15.8 сая, үйлдвэр дээрх сургалтад 232 хүн хамрагдаж 60.8 сая, мэргэжлийн болон давтан сургалтад 428 хүн хамрагдаж 70.7 сая, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээлэл өгөхөд 83 хүн хамрагдаж 0.6 сая, ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт зохион байгуулахад 83 хүн хамрагдаж 2.5 сая, ажилд зуучлах уулзалтад бэлтгэх 83 хүн хамрагдаж 4.1 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 15. Сургалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

| Он   | Хөдөлмөрт бэлтгэх сургалт |                    | Үйлдвэр дээрх сургалт |                    | Мэргэжлийн болон давтан сургалт |                    | ажил олгогчийн урамшуулал |                    | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх |                    | Ажлын байрны харилцаа,сэтгэл зүйн сургалт зохион байгуулах |                    | Ажилд зуучлах уулзалтад бэлтгэх |                    | Нийт дүн             |                    |
|------|---------------------------|--------------------|-----------------------|--------------------|---------------------------------|--------------------|---------------------------|--------------------|------------------------------------------------------------|--------------------|------------------------------------------------------------|--------------------|---------------------------------|--------------------|----------------------|--------------------|
|      | хамрагдсан хүний тоо      | Зарцуулсан хөрөнгө | хамрагдсан хүний тоо  | Зарцуулсан хөрөнгө | хамрагдсан хүний тоо            | Зарцуулсан хөрөнгө | хамрагдсан хүний тоо      | Зарцуулсан хөрөнгө | хамрагдсан хүний тоо                                       | Зарцуулсан хөрөнгө | хамрагдсан хүний тоо                                       | Зарцуулсан хөрөнгө | хамрагдсан хүний тоо            | Зарцуулсан хөрөнгө | хамрагдсан хүний тоо | Зарцуулсан хөрөнгө |
| 2016 |                           |                    | 168                   | 24.6               |                                 |                    | 20                        | 46.1               |                                                            |                    |                                                            |                    |                                 |                    | 188                  | 70.7               |
| 2017 | 95                        | 4.3                | 22                    | 12.5               | 189                             | 27.5               |                           |                    |                                                            |                    |                                                            |                    |                                 |                    | 306                  | 44.3               |
| 2018 | 95                        | 4.3                | 14                    | 9.7                | 79                              | 12.8               |                           |                    |                                                            |                    |                                                            |                    |                                 |                    | 188                  | 26.8               |
| 2019 | 95                        | 4.3                | 28                    | 14.0               | 65                              | 11.3               |                           |                    |                                                            |                    |                                                            |                    |                                 |                    | 188                  | 29.6               |
| 2020 | 95                        | 3.0                |                       |                    | 45                              | 9.5                |                           |                    |                                                            |                    |                                                            |                    |                                 |                    | 140                  | 12.5               |
| 2021 |                           |                    |                       |                    | 50                              | 9.6                | 42                        | 9.5                | 83                                                         | 0.6                | 83                                                         | 2.5                | 83                              | 4.1                | 341                  | 26.3               |
| Дүн  | 380                       | 15.8               | 232                   | 60.8               | 428                             | 70.7               | 62                        | 55.5               | 83                                                         | 0.6                | 83                                                         | 2.5                | 83                              | 4.1                | 1351                 | 210.1              |

Эх сурвалж: ХЭДС-ийн мэдээ, тайлан

## Аудитын илрүүлэлт

- Тухайн хөтөлбөрийн үр дүнд хөдөлмөрт бэлтгэх сургалт болон үйлдвэр дээрх сургалтад хамрагдаж тодорхой хувийн ажлын байртай болсон байх шалгуур үзүүлэлттэй боловч ажлын байртай болсон талаарх судалгаа байхгүй байна.

## 2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэх ажлын байр дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд 3761 хүнд 2,319.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 5649 хүнд 2,061.8 сая төгрөгийг зарцуулж байнгын 589, түр 3211, улирлын шинжтэй 383 ажлын байр бий болсон байна.

Хүснэгт 16. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн судалгаа (сая төгрөгөөр)

| Он   | Төлөвлөгөө          |                   | Гүйцэтгэл            |                    | Байнгын ажлын байр | Түр ажлын байр | Улирлын шинжтэй ажлын байр |
|------|---------------------|-------------------|----------------------|--------------------|--------------------|----------------|----------------------------|
|      | хамрагдах хүний тоо | Зарцуулах хөрөнгө | хамрагдсан хүний тоо | Зарцуулсан хөрөнгө |                    |                |                            |
| 2016 | 818                 | 338.4             | 908                  | 252.2              | 96                 | 634            | 40                         |
| 2017 | 478                 | 399.3             | 1533                 | 395.4              | 107                | 1139           | 57                         |
| 2018 | 766                 | 324.3             | 1075                 | 310.0              | 78                 | 417            | 192                        |
| 2019 | 746                 | 488.1             | 1065                 | 478.4              | 97                 | 517            | 94                         |
| 2020 | 533                 | 528.3             | 498                  | 384.3              | 104                | 291            |                            |
| 2021 | 420                 | 241.3             | 570                  | 241.3              | 107                | 213            |                            |
| Дүн  | 3761                | 2319.68           | 5649                 | 2061.8             | 589                | 3211           | 383                        |

Эх сурвалж: ХЭДС-ийн мэдээ

Ажлын байр дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд 310 хүнд 1,045.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөж гүйцэтгэлээр 473 хүнд 979.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 721 ажлын шинээр бий болсон байна.

Хүснэгт 17. АБД хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн судалгаа (сая төгрөгөөр)

| он   | Төлөвлөгөө          |                   | Гүйцэтгэл            |                    | Байнгын ажлын байр |
|------|---------------------|-------------------|----------------------|--------------------|--------------------|
|      | хамрагдах хүний тоо | Зарцуулах хөрөнгө | хамрагдсан хүний тоо | Зарцуулсан хөрөнгө |                    |
| 2016 | 90                  | 135.0             | 96                   | 126.0              | 211                |
| 2017 | 50                  | 150.0             | 92                   | 150.0              | 154                |
| 2018 | 46                  | 138.0             | 68                   | 138.0              | 115                |
| 2019 | 43                  | 215.0             | 82                   | 215.0              | 94                 |
| 2020 | 55                  | 277.0             | 77                   | 220.0              | 89                 |
| 2021 | 26                  | 130.0             | 58                   | 130.0              | 58                 |
| Дүн  | 310                 | 1,045.0           | 473                  | 979.0              | 721                |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад 793 хүн хамрагдаж 23.8 сая, борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд 621 хүнд 63.4 сая, ажил олгогчид олгох дэмжлэгт 50 ажил олгогчид 160.0 сая, нийтийг хамарсан ажилд 3266 хүнд 618.1 сая, зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 207 хүнд 80.2 сая, цагийн ажилд зуучлах 1.3 сая, бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалахад 238 хүнд 136.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 18. АБД хөтөлбөрийн зардлын судалгаа (сая төгрөгөөр)

| Үзүүлэлт                                   |                    | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | дүн  |
|--------------------------------------------|--------------------|------|------|------|------|------|------|------|
| Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт | Хамрагдсан хүн     | 137  | 166  | 151  | 150  | 49   | 140  | 793  |
|                                            | Зарцуулсан хөрөнгө | 4.1  | 5.0  | 4.5  | 4.5  | 1.5  | 4.2  | 23.8 |
| Борлуулалтын дэмжлэг болон                 | Хамрагдсан хүн     |      | 64   | 237  | 152  | 14   | 154  | 621  |

|                                                      |                    |      |       |      |       |      |       |
|------------------------------------------------------|--------------------|------|-------|------|-------|------|-------|
| ажлын байрны түрээсийн хөнгөлөлт                     | Зарцуулсан хөрөнгө | 8.5  | 13.0  | 15.4 | 14.6  | 12.0 | 63.4  |
| Ажил олгогчид олгох дэмжлэг                          | Хамрагдсан хүн     | 15   | 10    | 15   | 5     | 5    | 50    |
|                                                      | Зарцуулсан хөрөнгө | 37.2 | 26.0  | 50.2 | 21.5  | 25.1 | 160.0 |
| Нийтийг хамарсан ажил                                | Хамрагдсан хүн     | 634  | 1139  | 417  | 572   | 291  | 3266  |
|                                                      | Зарцуулсан хөрөнгө | 91.1 | 161.1 | 79.8 | 130.0 | 86.2 | 618.1 |
| Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ | Хамрагдсан хүн     |      | 149   | 44   | 14    |      | 207   |
|                                                      | Зарцуулсан хөрөнгө |      | 25.2  | 38.8 | 16.1  |      | 80.2  |
| Цагийн ажилд зуучлах                                 | Хамрагдсан хүн     |      |       |      |       |      | 0     |
|                                                      | Зарцуулсан хөрөнгө |      |       | 1.3  |       |      | 1.3   |
| Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах  | Хамрагдсан хүн     | 40   | 57    | 43   | 50    | 48   | 238   |
|                                                      | Зарцуулсан хөрөнгө | 31   | 33.6  | 22.2 | 24.6  | 24.5 | 136.0 |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Аж ахуй эрхлэлтийн сургалтыг ХХҮЕГ-ын даргын 2018 оны А/71 тоот тушаалын 02 дугаар хавсралтаар батлагдсан аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах эрх бүхий байгууллага болох “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн сургалтын байгууллагатай хамтран “Бизнесээ хэрхэн эхлэх вэ”, “Бизнесээ хэрхэн хөгжүүлэх вэ?”, “Төслөө хэрхэн боловсруулах вэ”, “Бизнесийнхээ санхүү бүртгэлийн хэрхэн хөтлөх -вэ?”, зэрэг агуулгын хүрээнд бизнесийн анхан шатны мэдлэг олгох сургалтууд жил бүр зохион байгуулсан байна.

Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд 2016-2021 онд 621 хүнд 63.4 сая төгрөг зарцуулсан бөгөөд 30 иргэний түрээсийн хөнгөлөлтөд 36.0 сая, борлуулалтын цэгийн үйл ажилагааны зардалд 591 иргэний 27.4 сая төгрөг зарцуулсан байна.

#### Нийтийг хамарсан ажил

- **2017 онд** Баянхонгор, Баянцагаан, Эрдэнэцогт сумуудтай хамтран зохион байгуулж нийт 450 иргэнийг түр ажлын байранд зуучилж 40.5 сая, мөн Өлзийт, Жинст, Баянлиг, Баянговь, Шинэжинст Баянбулаг, Гурванбулаг Бууцагаан, Заг, Галуут, Бөмбөгөр, Эрдэнэцогт, Баянхонгор сумдад нийтийг хамарсан ажлын төслийг үргэлжлүүлэн зохион байгуулж 689 хүнийг түр ажлын байранд зуучилж 120.6 сая төгрөгийг зарцуулсан.
- **2018 онд** Илгээлтийн эзэн хөтөлбөрийг цаг хүндэрсэн 13 суманд зохион байгуулж 181 малчин өрхөд 181 иргэн очиж ажиллаж 50.6 сая, Баянхонгор, Жинст, Баян-Өндөр, Бөмбөгөр сумдын төслүүдийн хүрээнд 236 иргэн ажиллаж 29.1 сая төгрөгийн урамшуулал авсан.
- **2019 онд** Өлзийт, Жинст, Хүрээмарал, Баянхонгор сумдад ногоон байгууламж нэмэгдүүлэх, хорт ургамлыг устгах, үлийн цагаан оготно устгах, нийтийн эзэмшлийн зам талбайд тохижилт хийх, сум суурин газруудын хог цэвэрлэгээний чиглэлээр ирүүлсэн 12 төсөлд 572 иргэнд 130.0 сая төгрөгийг олгож түр ажлын байраар хангасан.
- **2020 онд** Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 77 иргэн хамрагдаж 220.0 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэг үзүүлж 89 байнгын байнгын ажлын байраар хангагдсан.
- **2021 онд** Шаргалжуут багийн 8 багийн сэг зэм устгах, Баянхонгор сумын Цагаан чулуут 5 дугаар багийн 2,3 км ойн зурвасын хайс хамгаалалт, засварын ажил, “Мазаалай” парк, “Оготонотой булаг” орчимд хийгдэж буй “Ногоон суварга” байгуулах зэрэг ажлуудад 213 иргэн ажиллаж 70.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

#### 3.Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Монгол улсын иргэн, 15-34 насны залуучууд, ялангуяа ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж

байгаа залуучууд түүнчлэн их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид болон төгсөгчид хамрагдах энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд 436 хүнд 441.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 872 хүнд 371.4 сая төгрөгийг зарцуулж 68 байнгын ажлын байр бий болгосон байна.

**Хүснэгт 19. Төсөв гүйцэтгэлийн судалгаа (сая төгрөгөөр)**

| Он   | Төлөвлөгөө    |                   | Гүйцэтгэл      |                    | Байнгын ажлын байр |
|------|---------------|-------------------|----------------|--------------------|--------------------|
|      | Хамрагдах хүн | Зарцуулах хөрөнгө | Хамрагдсан хүн | Зарцуулсан хөрөнгө |                    |
| 2016 | 80            | 99.2              |                |                    |                    |
| 2017 | 109           | 52.5              | 113            | 52.5               | 29                 |
| 2018 | 95            | 93.8              | 96             | 78.9               | 21                 |
| 2019 | 100           | 177.9             | 523            | 177.6              | 16                 |
| 2020 |               |                   |                |                    |                    |
| 2021 | 52            | 18.4              | 140            | 18.4               | 2                  |
| Дүн  | 436           | 441.8             | 872            | 327.4              | 68                 |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Залуучуудын гарааны бизнесийн дэмжих арга хэмжээний хүрээнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгээр 2016-2019 онд 89 хүнд 340.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 58 хүнд 265.0 сая төгрөгийг олгож, 66 ажлын байрыг шинээр бий болгосон байна. Эргэн төлөгдөх зээлийг 2016, 2020, 2021 онд олгоогүй байна. Мөн 2016 онд санхүүжилт оройтож орж ирсэнтэй холбоотой эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олгоогүй байна

**Хүснэгт 20. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг (сая төгрөгөөр)**

| Он   | Төлөвлөгөө |         | Гүйцэтгэл |         | Байнгын ажлын байр |
|------|------------|---------|-----------|---------|--------------------|
|      | хүн        | хөрөнгө | хүн       | хөрөнгө |                    |
| 2016 | 35         | 70.0    | 0         | 0.0     |                    |
| 2017 | 25         | 50.0    | 29        | 50.0    | 29                 |
| 2018 | 14         | 70.0    | 13        | 65.0    | 21                 |
| 2019 | 15         | 150.0   | 16        | 150.0   | 16                 |
| 2020 |            |         |           |         |                    |
| 2021 |            |         |           |         |                    |
| Дүн  | 89         | 340.0   | 58        | 265.0   | 66                 |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Аж ахуй эрхлэх сургалтад 240 хүн хамрагдаж 7.2 сая, борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийг 276 хүн 16.9 сая, оюутны хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах, цагийн ажилд зуучлах 8 хүн 0.4 сая, гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах 158 хүн 20.0 сая, Шилдэг Старт-Ап залуучуудын багийг сонгон шалгаруулах 2 хүн 10.0 сая, Старт-Ап залуучуудад ментор хийх 130 хүн 8.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

**Хүснэгт 21. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн зардлын судалгаа (сая төгрөгөөр)**

| Үзүүлэлт                                                                       |                    | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | ДҮН  |
|--------------------------------------------------------------------------------|--------------------|------|------|------|------|------|------|
| Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт                                     | Хамрагдсан хүн     | 84   | 71   | 85   |      |      | 240  |
|                                                                                | Зарцуулсан хөрөнгө | 2.5  | 2.1  | 2.6  |      |      | 7.2  |
| Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт                    | Хамрагдсан хүн     |      | 4    | 272  |      |      | 276  |
|                                                                                | Зарцуулсан хөрөнгө |      | 1.8  | 15.1 |      |      | 16.9 |
| Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах, цагийн ажилд зуучлах | Хамрагдсан хүн     |      |      |      |      | 8    | 8    |
|                                                                                | Зарцуулсан хөрөнгө |      |      |      |      | 0.4  | 0.4  |
|                                                                                | Хамрагдсан хүн     |      | 8    | 150  |      |      | 158  |

|                                                          |                    |      |      |      |
|----------------------------------------------------------|--------------------|------|------|------|
| Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах | Зарцуулсан хөрөнгө | 10.0 | 10.0 | 20.0 |
| Шилдэг Старт-Ап залуучуудын багийг сонгон шалгаруулах    | Хамрагдсан хүн     |      | 2    | 2    |
|                                                          | Зарцуулсан хөрөнгө |      | 10.0 | 10.0 |
| Старт -Ап залуучуудад ментор хийх                        | Хамрагдсан хүн     |      | 130  | 130  |
|                                                          | Зарцуулсан хөрөнгө |      | 8.0  | 8.0  |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалтыг 2016 онд “Өлзийт МСҮТ”-тэй хамтран зохион байгуулж 15-24 насны 84 төгсөгч залуучуудыг хамруулан сургаж, сургалтын зардалд 2.5 сая, 2019 онд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний дэргэдэх сургалтын төвтэй хамтран зохион байгуулж, тус сургалтад Политехникийн коллежийн 85 төгсөгч хамрагдсанд 2.6 сая төгрөг зарцуулсан байна.

Швейцарын хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 2018 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн арга хэмжээг зохион байгуулж 55 залуу иргэд хамрагдсан бөгөөд тэд баг бүрдүүлэн өөрсдийн бизнес загвараа боловсруулан өрсөлдсөн бөгөөд Жимсний мод, Сэрэлт, Балчиргана, Цагаан алт, Старт гэсэн багууд шалгарсан байна. Жимсний мод баг тус хөтөлбөрөөс 1 дүгээр байранд шалгарч Швейцарын хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр 10.0 сая төгрөгийг эргэн төлөлтгүй санхүүгийн дэмжлэгт хамрагдах эрх авч дараагийн хурдасгуур программд хамрагдсан байна.

Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 2021 онд 18-34 насны нийт 124 залуучууд бүртгүүлж сургалтыг Улаанбаатар хотын “Best metod” сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулсан байна. Хурдасгуур хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад 5 баг шалгарч 5 долоо хоногийн турш төслийн шалгаруулалт дээр ажиллаж 2 дугаар шатанд 2 баг шалгарч эхний байранд орсон багт 6.0 сая, 2 дугаар эзэлсэн багт 4.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлгүй дэмжлэгийг олгосон байна.

#### 4.Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар цөөн малтай болон малгүй иргэдийг ажлын байртай болгоход хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд 920 хүнд 1,532.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 2,182 хүнд 1,807.2 сая төгрөгийг зарцуулж, үүнээс 1,696 хүнийг сургалтад хамруулан 143.5 сая төгрөгийг зарцуулан, 486 хүнд 1,663.7 сая төгрөгийн зээл олгож 324 иргэнийг малжуулсан байна.

Хүснэгт 22. Малчдын хөдөлмөр эрхлэлтийн зардлын судалгаа (сая төгрөгөөр)

| он   | Төлөвлөгөө          |                   | Гүйцэтгэл            |                    | хувь                 |                    | Байнгын ажлын байр |
|------|---------------------|-------------------|----------------------|--------------------|----------------------|--------------------|--------------------|
|      | хамрагдах хүний тоо | Зарцуулах хөрөнгө | хамрагдсан хүний тоо | Зарцуулсан хөрөнгө | хамрагдсан хүний тоо | Зарцуулсан хөрөнгө |                    |
| 2016 | 65                  | 292.5             | 64                   | 279.7              | 98.5                 | 95.6               | 65                 |
| 2017 | 42                  | 210.0             | 100                  | 300.0              | 238.1                | 142.9              | 100                |
| 2018 | 50                  | 250.0             | 100                  | 349.0              | 200.0                | 139.6              | 50                 |
| 2019 | 48                  | 240.0             | 100                  | 340.0              | 208.3                | 141.7              | 48                 |
| 2020 | 39                  | 195.0             | 100                  | 295.0              | 256.4                | 151.3              | 39                 |
| 2021 | 20                  | 100.0             | 22                   | 100.0              | 110.0                | 100.0              | 22                 |
| Дүн  | 264                 | 1287.5            | 486                  | 1663.7             | 184.1                | 129.2              | 324                |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд 264 өрхийг малжуулахаар 1,287.5 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 486 өрх айлыг малжуулж 1,663.7 сая төгрөгийг зарцуулсан ба орон нутгийн төсвийн “Илгээлтийн эзэн” хөтөлбөрийн хүрээнд

390.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс 1,273.7 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлсэн байна.

Судалгаа 23. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн судалгаа (сая төгрөгөөр)

| Он   | хамрагдах хүний тоо | Зарцуулах хөрөнгө | хамрагдсан хүний тоо | Зарцуулсан хөрөнгө | Байнгын ажлын байр |
|------|---------------------|-------------------|----------------------|--------------------|--------------------|
| 2016 | 65                  | 292.5             | 64                   | 279.7              | 65                 |
| 2017 | 42                  | 210.0             | 100                  | 300.0              | 100                |
| 2018 | 50                  | 250.0             | 100                  | 349.0              | 50                 |
| 2019 | 48                  | 240.0             | 100                  | 340.0              | 48                 |
| 2020 | 39                  | 195.0             | 100                  | 295.0              | 39                 |
| 2021 | 20                  | 100.0             | 22                   | 100.0              | 22                 |
| Дүн  | 264                 | 1,287.5           | 486                  | 1,663.7            | 324                |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Тус хөтөлбөрийн хүрээнд 2016 онд хөдөлмөрийн чадвартай 35 хүртэлх насны 13 сумын 65 өрхийг 279.7 сая төгрөгөөр малжуулсан ба Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 9 дүгээр тогтоолын 2.2.3 дахь заалтын дагуу 50 хувийг хөнгөлсөн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн “Илгээлтийн эзэн аймгийн дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 15 дугаар тогтоолоор “Илгээлтийн эзэн” аймгийн дэд хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 2.3 дах заалтад “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймаг, сумын комисс боловсруулан, үр дүнг жил бүр тооцож амжилттай хэрэгжүүлсэн өрхүүдэд олгосон дэмжлэгт орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн төлбөрөөс чөлөөлнө” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Энэ нь тус хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн 295 өрхийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн 287.6 сая, 2020 онд олгосон 100 өрхийн 100.0 сая төгрөгийг чөлөөлсөн байна.

Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 2019 онд 60 хүн хамрагдаж 33.7 сая, аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад 1,000 хүн хамрагдаж 46.9 сая, мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт арга хэмжээнд 636 хүн хамрагдаж 62.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 24. Малчдын хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээний зардлын судалгаа (сая төгрөгөөр)

|                                                             | Үзүүлэлт           | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | дүн  |
|-------------------------------------------------------------|--------------------|------|------|------|------|------|------|------|
| Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ | Хамрагдсан хүн     |      |      |      | 60   |      |      | 60   |
|                                                             | Зарцуулсан хөрөнгө |      |      |      | 33.7 |      |      | 33.7 |
| Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт                  | Хамрагдсан хүн     | 1000 |      |      |      |      |      | 1000 |
|                                                             | Зарцуулсан хөрөнгө | 46.9 |      |      |      |      |      | 46.9 |
| Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт   | Хамрагдсан хүн     | 126  | 100  | 100  | 100  | 100  | 110  | 636  |
|                                                             | Зарцуулсан хөрөнгө | 3.8  | 10.5 | 12.5 | 19.9 | 3.0  | 13.2 | 62.8 |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Тус хөтөлбөрт хамрагдсан малчдад мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт арга хэмжээг зохион байгуулсан байна.

- 2016 онд “Оюуны язгуур” сургалтын төвтэй хамтран зохион байгуулж 132 малчид оролцсон.
- “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-тай хамтран 2017-2021 онд малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгт хамрагдсан малчдад сургалт зохион байгуулж туршлага солилцох уулзалтыг зохион байгуулсан байна.

Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтыг 2016 онд Баянхонгор ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Политехникийн коллеж, Ус цаг уур шинжилгээний албатай хамтран “Малчин фермер” бүсчилсэн сургалтыг зохион байгуулж сургалтад 1000 малчин оролцож 46.9 сая төгрөгийг ХЭДС-аас зарцуулсан байна.

Аймгийн ХХҮГ-ын дэд даргын 2016 оны 11 дүгээр сарын 16-ний өдрийн 01 тоот удирдамжийн дагуу дотоод хяналт шинжилгээ хийсэн тайланд “Малчин фермер” 1000 малчны дөрөв дэх удаагийн сургалт хийх удирдамжийг 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдөр аймгийн Засаг дарга баталж дээр дурдсан байгууллагуудтай хамтран 20 сумын 1054 малчдад 4 ээлжээр сургалтыг зохион байгуулж 1054 малчны хоол, унаа, байр, халуун усанд оруулсны зардалд зарцуулсан нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2 дугаар зүйлийн 2.3.1<sup>28</sup> дэх заалт, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамжийн 2 дугаар зүйлийн 2.2<sup>29</sup> дах заалтыг тус тус зөрчсөн байна гэж дурдсан ба дараа онуудад энэ зөрчил гараагүй байна.

Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2019 онд хот сууринаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг цалин хөлстэй ажилд зуучилж тогтвортой ажлын байраар хангаж орлоготой болгох зорилгоор Жинст, Галуут, Эрдэнэцогт, Жаргалант, Өлзийт, Гурванбулаг, Заг, Баянбулаг, Шинэжинст сумдаас бог малд шилжүүлсэн тоогоор 600-с дээш толгой малтай 22 малчин өрхтэй 38 айл өрх гэрээгээр маллах маллахаар 1 жилийн хугацаатай гэрээ байгуулж ажил олгогч өрх айлгаас цалингийн зардлыг олгож, ХЭДС-аас нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрт 33.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

## 5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний ажил эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд 730 хүнд 507.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 668 хүнд 412.5 сая төгрөгийг зарцуулж 129 хүнийг байнгын ажлын байртай болсон байна.

Хүснэгт 25. ХБИ-ийн ХЭ-ийн зардлын судалгаа (сая төгрөгөөр)

| Он   | Төлөвлөгөө    |                   | Гүйцэтгэл      |                    | хувь           |                    | Байнгын ажлын байр |
|------|---------------|-------------------|----------------|--------------------|----------------|--------------------|--------------------|
|      | Хамрагдах хүн | Зарцуулах хөрөнгө | Хамрагдсан хүн | Зарцуулсан хөрөнгө | Хамрагдсан хүн | Зарцуулсан хөрөнгө |                    |
| 2016 | 152           | 64.5              | 56             | 43.2               | 36.8           | 67.0               | 45                 |
| 2017 | 156           | 80.1              | 179            | 62.3               | 114.7          | 77.8               | 46                 |
| 2018 | 117           | 69.0              | 135            | 57.4               | 115.4          | 83.2               | 38                 |
| 2019 | 113           | 74.5              | 173            | 71.7               | 153.1          | 96.3               |                    |
| 2020 | 113           | 106.4             | 42             | 65.2               | 37.2           | 61.3               |                    |
| 2021 | 79            | 112.7             | 83             | 112.7              | 105.1          | 100.0              |                    |
| Дүн  | 730           | 507.1             | 668            | 412.5              | 91.5           | 81.3               | 129                |

Санхүүгийн дэмжлэгээр 2016 онд хөгжлийн бэрхшээлтэй 39 иргэнд 39.0 сая төгрөгийн 1 хүнд 1.0 сая буцалтгүй дэмжлэг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгээр 2017-2021 онд 64 иргэнд 269.9 сая төгрөг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 132 иргэнд 249.0 сая төгрөгийг олгосон байна.

<sup>28</sup> Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ухааны сургалт явуулах, туршлага солилцох уулзалт зохион байгуулах, малын хашаа хороо барих, өвөлжилтийн бэлтгэл ажил хангах зэрэг дэмжлэг тусалцаа үзүүлэх бөгөөд энэхүү арга хэмжээний нийт зардал нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санааас малжуулах арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн 5 хувьас ихгүй байна.

<sup>29</sup> Аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалтыг зөвхөн хөтөлбөрийн 2.2-т заасан арга хэмжээнд хамрагдаж байгаа малчин өрхөд зориулан зохион байгуулах бөгөөд энэхүү удирдамжийн 1.5-д заасан хөрөнгөөр санхүүжүүлнэ

Хүснэгт 26. ХБИ-ийн санхүүгийн дэмжлэгийн судалгаа (сая төгрөгөөр)

| Он   | Төлөвлөгөө    |                   | Гүйцэтгэл      |                    |
|------|---------------|-------------------|----------------|--------------------|
|      | Хамрагдах хүн | Зарцуулах хөрөнгө | Хамрагдсан хүн | Зарцуулсан хөрөнгө |
| 2016 | 45            | 45.0              | 38             | 39.0               |
| 2017 | 16            | 48.0              | 34             | 40.0               |
| 2018 | 8             | 40.0              | 26             | 40.0               |
| 2019 | 9             | 45.0              | 29             | 45.0               |
| 2020 | 15            | 72.9              | 23             | 60.0               |
| 2021 | 16            | 64.0              | 20             | 64.0               |
| Дүн  | 109           | 314.9             | 170            | 288.0              |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ 41 хүн хамрагдаж 12.8 сая, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах арга хэмжээнд 10 хүн хамрагдаж 1.4 сая, борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт 62 хүн хамрагдаж 22.7 сая, аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад 196 хүн хамрагдаж 8.1 сая, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 97 хүн хамрагдаж 21.7 сая, ажил олгогчийн урамшуулалд 13 ажил олгогч хамрагдаж 48.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Хүснэгт 27. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээний зардлын судалгаа (сая төгрөгөөр)

| Үзүүлэлт                                                    |                    | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | дүн  |
|-------------------------------------------------------------|--------------------|------|------|------|------|------|------|------|
| Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ                               | Хамрагдсан хүн     |      | 21   | 19   |      |      | 1    | 41   |
|                                                             | Зарцуулсан хөрөнгө |      | 1.5  | 1.3  |      |      | 10.0 | 12.8 |
| Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ                      | Хамрагдсан хүн     |      | 10   |      |      |      |      | 10   |
|                                                             | Зарцуулсан хөрөнгө |      | 1.4  |      |      |      |      | 1.4  |
| Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт | Хамрагдсан хүн     |      | 3    | 4    | 43   | 3    | 9    | 62   |
|                                                             | Зарцуулсан хөрөнгө |      | 0.3  | 1.9  | 9.6  | 1.4  | 9.5  | 22.7 |
| Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт                  | Хамрагдсан хүн     |      | 24   | 66   | 66   |      | 40   | 196  |
|                                                             | Зарцуулсан хөрөнгө |      | 2.5  | 2.0  | 2.0  |      | 1.6  | 8.1  |
| Хөдөлмөр эрхлэлтийн сургалт                                 | Хамрагдсан хүн     | 18   | 25.0 | 17   | 13   | 16   | 8    | 97   |
|                                                             | Зарцуулсан хөрөнгө | 4.2  | 4.0  | 3.5  | 3.8  | 3.7  | 2.4  | 21.7 |
| Ажил олгогчийн урамшуулал                                   | Хамрагдсан хүн     |      | 2    | 3    | 3    |      | 5    | 13   |
|                                                             | Зарцуулсан хөрөнгө |      | 4.6  | 8.6  | 10.0 |      | 25.2 | 48.4 |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

Аймгийн ХХҮГ-ын 2018 хийсэн дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангаар “Ажбид” ХХК нь ажил олгогчийн урамшууллыг 2017 онд 3 хүн 6.9 сая, 2018 онд 1 хүн 2.9 сая, 2019 онд 3 хүн 10.6 сая төгрөг олгож, 12 сар НДШ төлсний дараа буцаагаад халаад дахин өөр иргэнтэй гэрээ байгуулан урамшууллыг жил дараалан авсан зөрчлийг илрүүлсэн байна.

Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.1<sup>30</sup> дэх заалтыг зөрчсөн байхад арга хэмжээ аваагүй байна.

## 6. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд:

Ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж, орлогын дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд ахмад настны зөвлөх үйлчилгээнд 245 ахмад настан 96.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр

<sup>30</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх заалтад зааснаас цөөн буюу 25 хүртэл ажилтантай ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол байнгын ажлын байраар хангасан хүний тоогоор

229 ахмад настан 89.4 сая, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгээр 40 ахмад настан 117.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 58 ахмад настан 114.5 сая нийт 287 ахмад настан 203.9 сая төгрөгийг зарцуулж 58 байнгын ажлын байртай болсон байна.

Хүснэгт 28. Ахмад мэргэжилтний зохион байгуулах арга хэмжээний зардлын судалгаа (сая төгрөгөөр)

| он   | Ахмад настаны зөвлөх үйлчилгээ |                   |                |                    |                                | санхүүгийн дэмжлэг |                   |                |                    | Нийт зарцуулсан хөрөнгө |                    | Байнгын ажлын байр |
|------|--------------------------------|-------------------|----------------|--------------------|--------------------------------|--------------------|-------------------|----------------|--------------------|-------------------------|--------------------|--------------------|
|      | Төлөвлөгөө                     |                   | Гүйцэтгэл      |                    |                                | Төлөвлөгөө         |                   | Гүйцэтгэл      |                    | хувь                    |                    |                    |
|      | Хамрагдах хүн                  | Зарцуулах хөрөнгө | Хамрагдсан хүн | Зарцуулсан хөрөнгө | сургалтад хамрагдсан иргэд тоо | Хамрагдах хүн      | Зарцуулах хөрөнгө | Хамрагдсан хүн | Зарцуулсан хөрөнгө | Хамрагдсан хүн          | Зарцуулсан хөрөнгө |                    |
| 2016 | 80                             | 16.0              | 60             | 12.1               | 560.0                          | 0.0                | 0.0               | 0              | 0.0                | 60.0                    | 12.1               |                    |
| 2017 | 90                             | 25.2              | 48             | 25.2               | 1294.0                         | 5.0                | 12.5              | 6              | 12.5               | 54.0                    | 37.7               |                    |
| 2018 | 29                             | 16.2              | 56             | 16.2               | 1065.0                         | 5.0                | 15.0              | 10             | 15.0               | 66.0                    | 31.2               |                    |
| 2019 | 15                             | 12.6              | 22             | 12.6               | 1234.0                         | 8.0                | 24.0              | 18             | 24.0               | 40.0                    | 36.6               |                    |
| 2020 | 18                             | 15.1              | 22             | 12.4               | 1058.0                         | 11.0               | 33.2              | 10             | 30.0               | 32.0                    | 42.4               | 18                 |
| 2021 | 13                             | 10.9              | 21             | 10.9               | 998.0                          | 11.0               | 33.0              | 14             | 33.0               | 35.0                    | 43.9               | 14                 |
| Дүн  | 245                            | 96.1              | 229            | 89.4               | 6209.0                         | 40                 | 117.7             | 58             | 114.5              | 287                     | 203.9              | 32                 |

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны ХЭДС-ийн мэдээ

## Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээ

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээнд 229 ахмад настан хамрагдаж сургалтад 6,209 иргэд сургалт зөвлөгөө авсан ба судалгаанаас харахад сүүлийн 2 жилд сургалтад хамрагдсан иргэдийн тоо буурсан байна.

### 7. Орон нутгийн хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл арга хэмжээ:

Орон нутгийн хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг 2018 оны 12 дугаар сард эмчилгээ, үйлчилгээний цогцолбор байгуулах 1 төсөлд 60.6 сая, усалгаатай газар тариалан, бэлчээрийн ургамал тариалах 1 төсөлд 40.0 сая, “Өнөөгийн Баянхонгор” сонины үйл ажиллагааг өргөжүүлэх 1 төсөлд 8.0 сая, жуулчны бааз байгуулах 1 төсөлд 30.0 сая, оёдлын цех байгуулах 2 төсөлд 30.0 сая, арьс шир боловсруулах үйлдвэр 4 төсөлд 20.0 сая, үхрийн аж ахуй байгуулах 1 төсөлд 11.4 сая, нийт 11 төсөлд 200.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

ХЭДС-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар эмчилгээ үйлчилгээ цогцолбор байгуулах нэг төсөл хэрэгжээгүй тул 2019 оны 01 дүгээр сард мөнгийг буцааж санд төвлөрүүлсэн байна.

### 8. Хүүхэд хамгаалагч төсөл арга хэмжээ:

Хөдөлмөр нийгмийн хамгааллыг сайдын 2019 оны А/116 дугаар тушаалаар “Хүүхэд хамгаалагч” төсөл хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн Цагдаагийн газрын 2 ахмад настан, аймгийн Цагдаагийн газар, ХХҮГ-тай гуравласан гэрээ байгуулан ХЭДС-аас урамшуулалд 2019 онд 2 хүнд 4.5 сая, 2020 онд 2 хүнд 1.7 сая, 2021 онд 2 хүнд 2.2 сая төгрөгийг тус тус олгосон байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар авсан санал асуулгад аймгийн 69 ажилгүй иргэнийг хамруулсан ба “Та төрөөс хэрэгжүүлж үйлчилгээ, хөтөлбөрт хамрагдаж байсан уу?” гэсэн асуултад оролцогчдын 55.2 хувь нь үгүй, 44.8 хувь нь тийм гэж хариулснаас үзэхэд иргэд ХЭДС-ийн хөтөлбөр, үйлчилгээнд бүрэн хамрагдахгүй байгааг харуулж байна.

**Монгол Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбараас 2021 оны 11-12 дугаар саруудад явуулсан “Аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа”-ны дүнгээс авч үзэхэд:**

Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс явуулж байгаа бодлого, шийдвэрийн үр дүн ямар байгаа талаар судалгаанд оролцогчдын 59.0 хувь нь үр дүн багатай, 37 хувь нь ямар ч үр дүнгүй хангалтгүй гэж үзсэн гэж дурджээ.



Мөн тус судалгаагаар “Ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн бодлого шийдвэрүүдтэй холбоотой тусламж дэмжлэг, зээлд хамрагдаж байгаа эсэх” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 15 хувь нь бүрэн хамрагдаж чаддаг, 32 хувь нь заримдаа хамрагдаж чаддаг, 53 хувь нь хамрагдаж чаддаггүй гэж хариулсан байна.


Хувийн аж ахуйн нэгж байгууллагууд зээл тусламжид хамрагдаж чаддаггүй шалтгааныг мэдээлэл өгдөггүй, нээлттэй биш; намын харьяалал хардаг, танил тал байдаггүй; зээлийн шалгуур өндөр, банкны шаардлага хангадаггүй; хувийн хэвшлүүдэд дэмжих бодлого хангалтгүй; бичиг баримт, цаг хугацаа их шаарддаг гэж хариулсан байна.

ХЭДС-аас олгосон санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан боловч, төсөл арга хэмжээнд олон хүнийг хамруулах зорилгоор санхүүгийн дэмжлэгийг төсөлд заасан хэмжээнээс доогуур олгож, хэт жижиглэснээс төсөлд заасан тоног төхөөрөмж, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй, цаашлаад хугацаандаа санхүүгийн дэмжлэгийг буцаан төлөхгүй байх эрсдэлийг дагуулж байна.


Иймд ХЭДС-аас олгож байгаа хөтөлбөр, арга хэмжээний тоо цөөрүүлж, нэг иргэнд ногдох санхүүгийн дэмжлэгийг ажлын байр бий болох төсөвт өртөгтэй уялдуулан, хэт жижиглэн олгохгүй байх чиглэлийг баримтлах саналыг ХХҮЕГ-т ҮАГ-аар дамжуулан уламжлав.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар Баянхонгор сумын 29, Өлзийт сумын 20, Гурванбулаг сумын 20, нийт 69 иргэнээс санал асуулга авсан, санал асуулгад оролцогчдын 46.4 хувь нь эрэгтэй, 53.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Судалгаанд оролцогчдын 39.1 хувь нь ажил эрхэлж байгаагүй гэсэн бол ажил эрхэлж байсан хүмүүсийн ихэнх нь хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарт ажилласан байна.



Судалгаанд оролцогчдын 8.9 хувь нь мэдээллийг хангалтгүй гэж үзэж, 45.6 хувь нь баг, хорооноос, 20.3 хувь нь цахим орчноос мэдээллийг авдаг гэсэн бөгөөд өөрийн оршин суугаа газарт ажлын байрны олдоц хангалтгүй гэж 92.8 хувь нь үнэлжээ.



## 2.4. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг жилд дунджаар 737 суралцагч төгсөж, тэдний 55.9 хувь нь ажлын байртай болжээ.

2.4.1. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

2.4.2. Баянхонгор аймагт Политехник коллеж, “Өлзийт” МСҮТ зэрэг мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Баянхонгор аймгийн Политехник коллеж 2016-2021 онд 10,285.8 сая төгрөгийн санхүүжилт авснаас 98.7 буюу 10,285.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 1.3 хувь буюу 136.4 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна. Харин “Өлзийт” МСҮТ нь суралцагчдын хувьсах зардлаар тооцон улсын төсвөөс 2016-2021 онд нийт 1,125.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүснэгт 28. Мэргэжлийн боловсролын байгууллагын санхүүжилт (сая төгрөгөөр)

| Он   | Политехник коллеж        |                        | "Өлзийт" МСҮТ   |                                                     |
|------|--------------------------|------------------------|-----------------|-----------------------------------------------------|
|      | Улсын төсвийн санхүүжилт | Үйл ажиллагааны орлого | Нийт санхүүжилт | Улсын төсвийн санхүүжилт /Хувьсах зардлаар тооцсон/ |
| 2016 | 1,515.6                  | 32.1                   | 1,547.7         | 176.9                                               |
| 2017 | 1,506.0                  | 32.8                   | 1,538.8         | 121.2                                               |
| 2018 | 1,505.3                  | 27.3                   | 1,532.6         | 144.6                                               |
| 2019 | 1,807.2                  | 17.4                   | 1,824.6         | 244                                                 |
| 2020 | 1,925.2                  | 14.5                   | 1,939.7         | 195.5                                               |
| 2021 | 2,026.5                  | 12.4                   | 2,038.9         | 243.7                                               |
| Дүн  | 10,285.8                 | 136.4                  | 10,422.3        | 1,125.9                                             |

Эх сурвалж: Байгууллагуудаас ирүүлсэн мэдээ, тайлан

Аймгийн Политехник коллеж нь 24 мэргэжлийг олгож байгаагаас 1 жилийн хугацаатай 19, 1.5 жилийн хугацаатай 5 мэргэжлээр сургаж диплом олгодог, 2.5 жилийн хугацаатай 12 мэргэжлээр сурган мэргэжлийн үнэмлэх болон бүрэн дунд боловсролыг олгож, харин 3 жилийн хугацаатай сургалтаар 3 мэргэжлээр сургаж, барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарт дадлагажуулж ажилладаг байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны сайдын 2006 оны 308 дугаар тушаалаар “Өлзийт МСҮТ” нь байгуулагдаж, хүнсний ногооны фермер, сүү, сүүн бүтээгдэхүүний технологийн ажилтан, ойжуулагч гэсэн 3 мэргэжлээр элсэлт авч, 1 жилийн хугацаатай сурган сертификат олгодог байна.

Эдгээр байгууллагууд суралцаж төгссөн суралцагчдаас 6 сарын дараа мөшгих судалгааг авч бий болсон ажлын байрны тооны мэдээллийг авдаг байна.

Судалгаа 29. Мэргэжлийн боловсролын сургалтад хамрагдсан суралцагч, ажлын байрны тоо

| Он   | Политехник коллеж     |                      |                               |                                       | "Өлзийт" МСҮТ         |                      |                               |                                       |
|------|-----------------------|----------------------|-------------------------------|---------------------------------------|-----------------------|----------------------|-------------------------------|---------------------------------------|
|      | Нийт суралцагчдын тоо | Нийт төгсөгчдийн тоо | Ажлын байртай төгсөгчдийн тоо | Ажлын байртай болсон төгсөгчдийн хувь | Нийт суралцагчдын тоо | Нийт төгсөгчдийн тоо | Ажлын байртай төгсөгчдийн тоо | Ажлын байртай болсон төгсөгчдийн хувь |
| 2016 | 981                   | 544                  | 201                           | 36.9                                  | 320                   | 320                  | 96                            | 30.0                                  |
| 2017 | 821                   | 486                  | 288                           | 59.3                                  | 320                   | 320                  | 204                           | 63.8                                  |
| 2018 | 751                   | 398                  | 179                           | 45.0                                  | 300                   | 300                  | 200                           | 66.7                                  |
| 2019 | 725                   | 452                  | 223                           | 49.3                                  | 400                   | 400                  | 285                           | 71.3                                  |
| 2020 | 898                   | 362                  | 152                           | 42.0                                  | 400                   | 399                  | 315                           | 78.9                                  |
| 2021 | 991                   | 339                  | 188                           | 55.5                                  | 400                   | 398                  | 272                           | 68.3                                  |
| ДҮН  | 5167                  | 2581                 | 1231                          | 47.7                                  | 2140.0                | 2137.0               | 1372.0                        | 64.2                                  |

Эх сурвалж: Байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээ

Мөшгих судалгаанаас харахад Политехник коллеж, "Өлзийт МСҮТ"-д суралцаж төгссөн суралцагчдын ажлын байрны тоо 2016 онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

Гэвч дээрх ажлын байрны дийлэнх нь барилга, газар тариалан зэрэг улирлын чанартай салбарт ажилладаг байна.

Мэргэжлийн боловсролын байгууллагууд төгсөгчдийг ажлын байраар хангах талаар аймгийн ХХҮГ, аймгийн ЗДТГ-ын НБХ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах уялдаа холбоог сайжруулах нь зүйтэй тул аймгийн ЗДТГ-ын НБХ-т энэ талаар зөвлөмжийг хүргүүлэв.

## 2.5. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгээ өгсөн байна.

2.5.1. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д зааснаар Засгийн газар нь *"Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх"* гэж заасан байна.

Тус зорилтын хүрээнд УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлд дараах хөнгөлөлт чөлөөлөлтийг үзүүлсэн байна.Үүнд:

1. Цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн 3.1.а.б.в.<sup>31</sup>-д зааснаас бусад хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд цар тахлын улмаас үйл ажиллагааны орлого буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд 2020-2021 онд тайлан ирүүлсэн аж ахуй нэгжүүдэд Нийгмийн даатгалын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх заасны заасан байна. Тус заалтын дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд 2020 онд 383 аж ахуй нэгжид 2,478.2 сая, 2021 онд 405 аж ахуй нэгж байгууллагын 564.6 сая нийт 3,042.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлсөн байна.
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад

<sup>31</sup> а/төрийн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагч;

б/төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч;

в/гадаад улс, олон улсын байгууллагын эзэл, тусламжаар бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсний төлбөрөөс цалин авч нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөх даатгуулагч.

Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод мөн хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлөх гэж заасны дагуу 2020 онд 120 аж ахуй нэгжид 253.7 сая төгрөгийг хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлжээ.

Хүснэгт 30. НДШ, орлогын татварын хөнгөлөлт чөлөөлөлт (Сая төгрөгөөр)

| № | Хөнгөлөлт, чөлөөлөлтийн төрөл | ААН-ийн тоо | Хамарсан он |       | ДҮН     |
|---|-------------------------------|-------------|-------------|-------|---------|
|   |                               |             | 2020        | 2021  |         |
| 1 | Нийгмийн даатгалын шимтгэл    | 788         | 2,478.2     | 564.6 | 3,042.8 |
| 2 | Орлогын албан татвар          | 120         | 253.7       | 0     | 253.7   |
|   | ДҮН                           | 908         | 2,731.9     | 564.6 | 3,296.5 |

Эх сурвалж аймгийн НДХ, татварын хэлтсийн судалгаа

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 9-ний өдрийн 1 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Цар тахлын үед аж ахуй нэгжийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийг баталсан байна.

Коронавируст халдвар (Ковид)-ын цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй, эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах, санаачилгыг дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршдог байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд 2021 онд иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулахад 130.0 сая төгрөгийг баталсан.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн 02 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл, төсвийн хуваарь”, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэгийг аймгийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай” ” А/385 дугаар захирамжаар “Явган хүний хавтан үйлдвэрлэх”, “Явган хүний зам, талбай, хавтан тавих ажил”, “Аймгийн төвийн ногоон байгууламж, ойн зурвас байгуулах ажил” зэрэг ажлуудад төлөвлөгөө гарган баталж, “Хот, тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг түшиглэж 58 иргэнд дунджаар 2.2 сая, нэг иргэнд 2.0-2.5 сая төгрөгийг төсөл сонгон шалгаруулалтгүйгээр дээрх 130.0 сая төгрөгийг олгосон байна.

Эдгээр иргэдийг “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын байран дээр дадлагажуулан үйл ажиллагаа явуулсан байна. Уг санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 3 жилийн хугацаанд орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр гэрээ байгуулсан нь дээрх хөтөлбөрийн 4.1<sup>32</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд дээрх зөрчилд ХЭДС-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “Цаашид ХЭДС-ийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 23.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулж байх” зөвлөмжийг өгсөн байна.

2.5.2. Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна.

Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020

<sup>32</sup> Аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 35 ба түүнээс дээш насны энэ хөтөлбөрийн 2.3, 2.4-т заасан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн болон гадаад улсад хөдөлмөрлөж байгаад буцаж иргэний боловсруулсан ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах зорилготой төслийг хэрэгжих үндэслэлийг харгалзан шалгаруулж 5.0 хүртэлх сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатайгаар 1 удаа олгоно.

оны “Коронавируст халдвар /covid-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2021 оны 93, 122, 310 дугаар тогтоолоор дараах арга хэмжээнүүдийг авсан байна.

Тус тогтоолын хоёрдугаарт иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээ авсан байна.

- ✓ Монгол Улсын иргэний Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх гэсэн заалтын дагуу Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн судалгаагаар 2020 онд 318 татвар төлөгчийн 616.6 сая төгрөгийг чөлөөлсөн байна.
- ✓ Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгох гэж заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн судалгаагаар 59 аж ахуй нэгжид ажилгүйдлийн даатгалын сангаас 307.2 сая төгрөгийг олгосон байна.

2.5.3. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.

Монгол улсын Засгийн газар, Монгол банкнаас авч хэрэгжүүлж буй 10 их наяд цогц төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.

1. Цогц төлөвлөгөөний 2.1<sup>33</sup> ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 981 иргэнд 28,582.0 сая, 78 аж ахуй нэгж байгууллагад 12,818.0 сая, нийт 41,400.0 сая төгрөг олгосон;
2. Цогц төлөвлөгөөний 2.1<sup>34</sup> заалтын дагуу “Репо” санхүүжилтээр 65 иргэнд 6,083.0 сая, 14 аж ахуй нэгж байгууллагад 2,897.0 сая, нийт 8,981.0 сая төгрөг олгосон;
3. Цогц төлөвлөгөөний 2.5<sup>35</sup> дах заалтын дагуу “Хөдөө аж зээлийн санхүүжилтээр 1668 иргэнд 10916.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Хүснэгт 31. Монгол банкнаас өгсөн зээлийн судалгаа (сая төгрөгөөр)

| №                                    | Үзүүлэлт     | Хүлээн авсан хүсэлт |            | Олгосон санхүүжилт |            |
|--------------------------------------|--------------|---------------------|------------|--------------------|------------|
|                                      |              | Тоо                 | Мөнгөн дүн | Тоо                | Мөнгөн дүн |
| Ажлын байрыг дэмжих зорилтын хүрээнд |              |                     |            |                    |            |
| 1                                    | Иргэн        | 1634                | 56,308.3   | 981                | 28,582.0   |
| 2                                    | Аж ахуй нэгж | 296                 | 53,464.2   | 78                 | 12,818.0   |
|                                      | Дүн          | 1930                | 109,772.5  | 1,059              | 41,400.0   |
| Репо санхүүжилт                      |              |                     |            |                    |            |
| 1                                    | Иргэн        | 70                  | 6,867.0    | 65                 | 6,083.5    |

<sup>33</sup> Ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 3.0 их наяд төгрөг хүртэлх зээлийг Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог ашиглан, банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгох)

<sup>34</sup> Мөнгөний бодлогын зорилтод нийцүүлэн Монголбанкны олгож байгаа репо санхүүжилтийн нийт эх үүсвэр, нэг зээлдэгчид олгох хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр Төвбангтай хамтран ажиллах

<sup>35</sup> Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлийг Хөгжлийн банк, арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан с а н х ү ж ү л э х (Засгийн газрын 2021 оны 59, 131 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 117 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

|                     |              |      |           |       |          |
|---------------------|--------------|------|-----------|-------|----------|
| 2                   | Аж ахуй нэгж | 14   | 2,897.0   | 14    | 2,897.5  |
|                     | Дүн          | 84   | 9,764.0   | 79    | 8,981.0  |
| Хөдөө аж ахуйн зээл |              |      |           |       |          |
| 1                   | Иргэн        | 1924 | 21,081.7  | 1,668 | 10,916.0 |
| Ипотехийн зээл      |              |      |           |       |          |
| 1                   | Иргэн        | 232  | 12,199.0  | 144   | 7,219.0  |
|                     | ДҮН          | 4170 | 152,817.5 | 2,950 | 68,516.0 |

Эх сурвалж. Монгол банкнаас ирүүлсэн судалгаа

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний 2 дугаар зорилгын 2.6<sup>36</sup> дах зорилтыг хэрэгжүүлэхээр заасан.

Зорилтын хүрээнд Залуучуудын дэмжих дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөл 2021-2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Аймгийн ХХҮГ-ын дарга 2021 оны 8 дугаар сарын 17-ний өдөр “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл зохион байгуулах тухай” А/33 дугаар тушаалаар баталж, тушаалаар “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийг зохион байгуулах, бүртгэх, сонгон шалгаруулах хэсгийг баталсан.

Тус төсөлд 2021 оны 8 дугаар сарын 16-27-ны хооронд 18-34 хүртэлх насны 297 залуучууд бүртгүүлснээс сонгон шалгаруулалтаар 171 иргэн тэнцсэн байна.

Төсөлд хамрагдсан залуучуудыг шаардлагатай эрүүл мэндийн үзлэгт хамруулан Улаанбаатар хотод 2021 оны 9 дүгээр сарын 01-ээс 2021 оны 11 дүгээр сарын 4-ний хооронд 112 залуучууд вакумжуулсан багц сургалтад хамруулсан байна.

Төсөлд оролцсон 112 залуучуудаас 111 буюу 99.1 хувь нь дадлагажиж, хүн тус бүр 1 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг авсан байна.

Ажил олгогч аж ахуй нэгж байгууллагуудтай уулзаж, сургалтад хамрагдаад ирсэн залуучуудыг ажлын байрны дадлагад гаргах уулзалт танилцуулга, дадлагын гуравласан гэрээг байгуулж ажилласны үр дүнд сургалтад оролцож дадлагажсан 111 залуучуудын 76 нь буюу 69.7 хувь нь байнгын ажлын байранд зуучлагдаж байнгын ажлын байртай болж улсын хэмжээнд эхний байранд орсон байна.

2.5.4. Монгол Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбараас 2021 оны 11-12 дугаар сард явуулсан “Аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа”-нд ковид 19 цар тахлын байгууллагад нөлөөлөх нөлөөллийг авч үзжээ.

Судалгаанд нийт 214 аж ахуйн нэгж хамрагдсанаас 65 хувь нь хувийн аж ахуйн байгууллага, 35 хувь нь төрийн байгууллага байсан бөгөөд судалгаанд оролцогч байгууллагын 86 хувь нь цар тахал сөргөөр нөлөөлсөн, 2 хувьд эерэг нөлөөлсөн, 10 хувьд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй гэжээ.

Судалгааны тайланд хувийн хэвшилд цар холбоотойгоор хүний нөөцийн тоогоо бууруулсан, олон хоног сул зогсолт хийсэн, бараа бүтээгдэхүүн ховордсон, хил хаагдсанаас үүдэлтэй түүхий эд материалын олдоц багассан зэрэг тайлбарыг өгсөн боловч аудитын явцад

<sup>36</sup> залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх

холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авсан судалгаагаар дараах статистик тоон үзүүлэлт гарсан байна. Үүнд:

- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс авсан судалгаагаар 2019-2021 онд шинээр 34 аж ахуйн нэгж бүртгүүлж, 17 аж ахуйн нэгж татан буугдсан;
- Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс авсан судалгаагаар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн аж ахуйн нэгж байгууллага, сайн дурын даатгуулагчийн тоо өссөн;
- Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн судалгаагаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн хуулийн этгээд, хувь хүний тоо өссөн үзүүлэлттэй байна.

Мэргэжлийн байгууллагуудаас авсан дээрх тоон үзүүлэлтээс харахад цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр Засгийн Газраас авч хэрэгжүүлсэн хэмжээнүүдийн үр дүнд аж ахуйн нэгжийн тоо буураагүй, харин цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж үйл ажиллагаа доголдож, орлого буурсан, зээлийн эргэн төлөлтийг төлөх боломжгүй болсон зэрэг нөлөөллүүд гарсан байна.

Аудитаар нийт 261.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 10.0 сая төгрөгийн 2 албан шаардлага өгч, 251.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 14 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан аймгийн ХХҮГ, аймгийн ЗДТГ, ХХААГ, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн хамт олонд талархал илэрхийлье.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусган орон нутгаас санхүүжүүлсэн боловч үр дүнг нэгтгэн тооцож ажиллаагүй байна.
2. Шинээр бий болсон ажлын байрыг төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн мэдээллээр тайлан мэдээг нэгтгэн тайлагнаж байгаа нь бодит байдлаас зөрүүтэй, ажилтны цалинг нийгмийн даатгалд мэдээлээгүй нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох арга хэмжээний үр дүнг бууруулах гол нөхцөл болж байна.
2. Аймгийн ХХҮГ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийгээгүй, мэдээллийн сан бүрдүүлээгүй, санд бүртгэлгүй иргэдээс судалгаа авч, дүн шинжилгээ хийх, тэднийг мэдээллээр хангах ажлыг хангалтгүй зохион байгуулсан байна.
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд шаардлагатай санхүүжилтийг төлөвлөхдөө харьяа байгууллагын саналыг харгалздаггүй, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг дутуу төлөвлөсөн, санд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг төлөвлөөгүй байна.
4. ХЭДС-аас олгосон эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн авлага хугацаандаа төлөгдөөгүйгээс нийт авлагын 31.0 хувь буюу 340.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн байна.
5. Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс төрийн байгууллагуудын үйл ажиллагааны харилцан уялдаа хангалтгүй, аймгийн хэмжээнд тухайн жилд бий болж буй ажлын байрыг нэгтгэн, тайлагнадаггүй байна.
6. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн LMIS программд ХНХЯ-ны харьяа байгууллагуудын мэдээлэл бүрэн холбогдоогүйгээс ашиглалт хангалтгүй, хөгжүүлэлтийг хийх шаардлагатай байна.
7. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг баталсан хэдий ч орон нутгаас төсөв батлаагүйгээс ажил хийгдээгүй байна.
8. “Ковид-19” цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгээ өгсөн байна.
9. Монгол Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар танхимын гэрээгээр гүйцэтгэсэн “Баянхонгор аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны ажлын тайланг хэлэлцээгүй, үр дүнг тооцоогүй байна.
10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бизнес инкубаторын зориулалтаар баригдсан “Ажилсаг” төвд түрээслэгч ямар хугацаанд ажиллах талаар бодлого, чиглэлийг тодорхойлоогүй, ахуйн үйлчилгээний төвд 6 аж ахуйн нэгж зориулалтаас бусад чиглэлийн үйл ажиллагаа явуулж байна.
11. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийг тусгасан Баянхонгор аймгийн ИТХ-аар баталсан дэд хөтөлбөрүүдийг боловсруулах үе шатанд хийж гүйцэтгэсэн тооцоолол, судалгааны ажлын баримт, материал зэрэг нотлох баримтыг ирүүлээгүй тул эдгээр аймгийн дэд хөтөлбөрүүдэд бүх талын оролцоо хангагдсан эсэхийг дүгнэх боломжгүй байна.
12. Орон нутгийн төсвөөс олгосон “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгээс төлөгдсөн 10.2 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэлгүй ХЭДС-д төвлөрүүлсэн байна.

---oOo---

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах албан тушаалтнуудад зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

### НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА

1. Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг бүрэн хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг орон нутагт хэрэгжүүлснээр ямар үр дүн гарч, ажлын байр шинээр нэмэгдэж байгаа эсэхэд хяналт тавьж, төрийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.
2. Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажилгүйдлийн түвшин, ажилгүй иргэдийн тоо мэдээллийн талаар нэгдсэн санг бүрдүүлж, мэдээллийн нэг эх үүсвэртэй болох.
3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусгах.
4. Баянхонгор аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, өнөөгийн чиг хандлагыг тодорхойлох ажилд мэргэжлийн байгууллагууд, бодлого тодорхойлох чиг үүрэг бүхий алба, хэлтсийн албан хаагчдыг оролцуулж байх
5. Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах асуудлыг судлан хэрэгжүүлэх.
6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бизнес инкубаторын зориулалтаар баригдсан “Ажилсаг” төвд гарааны бизнес эрхлэгч нар хэдий хугацаанд бойжиж, хэрхэн бие дааж ажиллах талаар бодлого, шийдвэр гаргах

### ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРСАНАА ТАНАА

1. Улс, орон нутгаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд бий болсон ажлын байрыг нийгмийн даатгалын мэдээнд тулгуурлан мэдээ тайланд тусгах, мэдээллийн үнэн зөв байдлыг хангаж ажиллах.
2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийн мэдээллийн сан бүрдүүлэх, Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлгүй иргэдээс судалгаа авч, дүн шинжилгээ хийх, тэднийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дах заалтыг хэрэгжүүлээгүй ажил олгогчийн мэдээллийг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт улирал бүр хүргүүлж, зөрчлийг арилгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэн буюу одой хүн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг тухайн жилд төлөвлөж, бүрэн төвлөрүүлж ажиллах.
4. ХЭДС-д төвлөрүүлсэн орон нутгийн хөрөнгөөс хуваарилсан санхүүжилтээс олгосон малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөлтийн 10.2 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон эргэн төлөгдөх зээлийг Монгол банкны мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэх.
6. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн LMIS программд ХНХЯ-ны харьяа байгууллагуудын мэдээллийг бүрэн авах, хөгжүүлэлтийг хийлгэх саналаа дээд шатны байгууллагад хүргүүлэх.

## ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА ЭНХЖАРГАЛ ТАНАА

1. Монгол Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар танхимын гэрээгээр гүйцэтгэсэн “Баянхонгор аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны ажлын тайланг хүлээн авч баталж, үр дүнг 2022 оны эхний хагас жилд тооцож аймгийн бодлого, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах.

## ДӨРӨВ. “БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.БАЯРСАЙХАН ТАНАА

1. Ахуйн үйлчилгээний төвд бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 6 аж ахуйн нэгжийн 8 өрөөг чөлөөлүүлж, ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглах.

Зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 5 дугаар сарын 15-ний дотор, холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

1. Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системд Хөдөлмөрийн яамны харьяа байгууллагуудын хоорондын мэдээллийг түргэн, шуурхай авах, иргэний талаарх мэдээллийг системээс дурын цаг хугацаагаар сонгон авах хөгжүүлэлтийг хийж, системийн ашиглалт, хурдыг сайжруулах зөвлөмжийг ХНХЯ-д уламжлах
2. ХЭДС-аас олгож байгаа хөтөлбөр, арга хэмжээнд хэт их байгааг тухайн жилийн зорилт арга хэмжээтэй уялдуулан, нэг иргэнд ногдох санхүүгийн дэмжлэгийг ажлын байр бий болох төсөвт өртөгтэй уялдуулан, хэт жижиглэн олгохгүй байх чиглэлийг баримтлах саналыг ХХҮЕГ-т уламжлах

---oOo---